

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН  
ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ  
ӨДӨР/БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-43
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	44-133
	1.Хуулийн төсөл эцэслэн батлах	45-51
	2.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүй өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2021.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, <b>дөрөв дэх хэлэлцүүлэг</b>/</i>	51-70
	3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, <b>анхны хэлэлцүүлэг</b>/</i>	70-97, 110-125
	4.Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалангаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад хандан Говь-Алтай аймгийн тахийн тал дахь говийн дархан цаазат газрын “Б” хэсгийн хамгаалалтын захиргааг нүүлгэн шилжүүлсэн талаарх тавьсан асуулгын хариуг сонсох	97-110
	5.“Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл <i>/Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 4 гишүүн 2021.03.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, <b>хэлэлцэх эсэх</b>/</i>	125-132
	6.“Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	132-133

### ***Хураангуй тэмдэглэл***

***Гурав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга О.Номинчимэг, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Ц.Болормаа, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх С.Эрдэнэчимэг, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ж.Батжаргал, Ш.Адъяаа, Б.Баярсайхан, Б.Баттөмөр, Х.Болорчулуун, С.Ганбаатар нарын тавьсан асуултад төсөл санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач О.Мөнхсайхан нар хариулж, тайлбар хийв.

*Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 20 минут үргэлжилж, 76 гишүүнээс 58 гишүүн хүрэлцэн ирж, 76.3 хувийн ирцтэйгээр 13 цаг 26 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 05 минутад эхлэв.*

### ***Дэлгэрэнгүй тэмдэглэл***

**Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Бямбацогт нарын 15 гишүүн өргөн мэдүүлсэн хуулийн анхны хэлэлцүүлгээ явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын эрхэм гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар танилцуулна. Сүхбаатар гишүүнийг индэрт урж байна.

**Ж.Сүхбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт, Баатарбилэг, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Даваасүрэн, Дамдинням, Мөнхбаатар, Мөнхбат, Мөнхцэцэг, Наранбаатар, Одонтуяа, Пүрэвдорж, Тэмүүлэн, Энхбаяр нарын 15 гишүүн 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн болно оо.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2021 оны дөрөвдүгээр тогтоолоор төслийг Байнгын хороо, чуулган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатараар ахлуулан гишүүдэд Адьяасүрэн, Баатарбилэг, Ганболд, Оюунчимэг, Мөнх-Оргил, Пүрэвдорж, Энхболд нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах үүрэг бүхий ажлын дэд хэсэгт холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан ажилласан болно оо.

Ажлын хэсэг болон дэд ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 22, 25, 26, 27, 28, 29, 11 дүгээр сарын 01, 02, 03, 04, 08-ны өдрүүдэд нийт 11 удаа хуралдаж, холбогдох зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон найруулгын саналыг боловсруулж Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оруулсан. Төрийн байгуулалтын байнгын хороо 2021 оны 10 дугаар сарын 27, 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн гучин есдүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс боловсруулсан Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зарчим, Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хяналт шалгалтын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрийн зохицуулалтыг нарийвчлах, Улсын Их Хурлын гишүүний асуулт асуулга, хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төсвийн хяналт, нэр дэвшигчийн сонсгол, хяналтын сонсгол явуулах санаачилга гаргах босго болон хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн, хугацаа, татан буугдах нөхцөл, хянан шалгах түр хорооны сонсголтой холбоотой ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан санал, түүнчлэн хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдох нийт 51 санал, зарчмын зөрүүтэй санал, найруулгын 3 багц саналыг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт төслийн дөрөвдүгээр зүйлийн дөрвийн хоёрын гуравт заасан төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрийг баримтлах зарчмыг нарийвчлах болсон үндэслэл, хяналт шалгалтын үр дүнд бий болох хариуцлагын тогтолцоотой холбоотой төслийн зохицуулалт суларсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн ажиллах хугацаа, Улсын Их Хурлын гишүүн нэгэн зэрэг хэдэн түр хороонд орж ажиллах талаар болон Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн

гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсгол хийх шаардлагатай эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхбат хянан шалгах, түр хорооны гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах санал гаргах босгын талаар асуулт асууж, хариулт авсан болно оо.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд төслийн дөрөвдүгээр зүйлийн дөрвийн хоёрын гурав дахь заалт, төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрийг баримтлах зарчим гэж Улсын Их Хурал хяналт, шалгалтаа хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулиар тогтоосон төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцлийг алдагдуулахгүй байх, хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, тагнуул, прокурор зэрэг байгууллагын хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг болон гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй байх гэсэн саналаар цөөнх болохоо илэрхийлсэн болно оо.

Байнгын хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн хянан шалгах түр хорооны нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах тухай хүсэлт гаргахтай холбоотой асуудлаар, мөн хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнтэй холбоотойгоор төслийн дөчин тавдугаар зүйлийн дөчин тавын гурав дахь хэсэгт Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох хэсгийг эш татах талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхболд хянан шалгах түр хороо татан буугдах нөхцөл, ажиллах хугацааны талаар зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Байнгын хороо ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан үг, аваагүйгээр нь бүлэглэн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын Хууль зүйн сургуулийн багш, доктор, Үндсэн хууль судлаач Одонхүүгийн Мөнхсайхан.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуухаас өмнө энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье ээ.

11 дүгээр сарын 14-нд Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг Сажаа овогтой Мөнхөө, Жадамба овогтой Цээпил нарын охин болж мэндэлжээ. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгтээ төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон танай гэр бүлд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс хүсэн ерөөе өө.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Кнопоо дар. Байна уу гээд байна шүү дээ. Та сая төсөв батлах үед саналаа өгөөгүй юм байлгүй. Тэгээд кноп чинь гацчихаж. Картаа сугалж аваад дахиад уншуул. Хаагаагүй байгаа шүү дээ.

Болорчулуун гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг.

**М.Оюунчимэг:** Баярлалаа. Төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүлсэнд баярлалаа. Төсөв хэлэлцэх өдөр болгон ингээд төрсөн өдрийн мэндчилгээг бас хүргэдэг юм. Тэгээд энэ бас хувь заяа гэж бодож байна. Баярлалаа, зүтгэнэ ээ.

Энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль бол өөрөө маш чухал хууль байгаа юм аа. Гол нь юундаа чухал вэ гэхээр. Өнөөдөр бид нар ингээд хууль батлаад л гаргадаг. Энэ тухайн салбарт зайлшгүй шаардлагатай эрх зүйн зохицуулалтуудыг бид хийдэг. Үүнийг яг хэрэгжих шатан дээр алдаа дутагдлууд маш их байгаа. Ганцхан жишээ хэлэхэд сая манай Нийгмийн бодлогын байнгын хорооноос эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх энэ хэд хэдэн хууль, эрүүл мэндийн тухай хууль, эрүүл мэндийн даатгалын тухай хууль, эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиудыг бид 2019 онд заримыг нь шинэчлэн баталж, заримыг нь нэмэлт өөрчлөлт оруулаад маш чухал хуулиуд баталсан. Сая бид нар ингээд шалгалтын ажлын хэсэг Батлут гишүүнээр ахлуулаад явахад хуулийн хэрэгжилт бол үнэхээр жаахан хангалтгүй, тэгээд бас удаашралтай. Дунд нь зөрчил жишээлбэл маш их байдаг. Тэгээд бид нар шалгаад л үлддэг. Харин энэ шалгаад гарсан зөрчлүүдийг зарим нь бүр ноцтой зөрчил байхад тэрийг бид одоо яаж арилгуулах вэ, хэнд, яаж хариуцлага тогтоох вэ? Энэ асуудал бол ерөнхийдөө нэг жоохон учир дутагдалтай байгаад байгаа юм. Бид Засгийн газарт тогтоолоор үүрэг чиглэл өгдөг. Засгийн газар цаасаар бидэн нэг хариулдаг. Гэтэл тэнд яг үүссэн үр дагаврыг арилгах тал дээр дутагдал байгаад байдаг.

Яг өнөөдөр энэ чухал хуулийн төсөл орж ирж байна. Тэгэхээр бид энэ хуулийг бол үнэхээр нухацтай бидний одоо Улсын Их Хурал өөрийнхөө хяналт шалгалтын үүргээ үнэхээр сайн биелүүлж чадвал Засгийн газар энэ үйл ажиллагаануудыг өөрөө шуурхай хийх бололцоо бүрдэх юм аа. Тийм ч учраас Төрийн байгуулалтын байнгын хороон дээр зүйл, заалт бүрээр нь нэлээд нухацтай ингээд ярьсан. Тэгээд зүгээр нэг шүдгүй арчсан шиг хууль гарах биш, бид яг үүсэж байгаа асуудлыг Улсын Их Хурал хяналт шалгалтынхаа хүрээнд шийдэж чаддаг асуудлыг гаргаж тавьдаг. Засгийн газар нь тэрийг одоо хэрэгжүүлдэг энэ чухал байгаа. Тийм учраас би өнөөдөр орж ирж байгаа энэ хуулийг нэгд 100 хувь дэмжиж байгаа,

Хоёрт, энд бол бид бол үнэхээр ач холбогдол өгч, чухал саналуудыг тусгаж, ингэж оруулах ёстой. Ялангуяа Улсын Их Хурлын Байнгын хороодын болоод түр хорооны тухайн асуудлаар гаргасан хяналт шалгалтын тэр баримт бичгийг бид хэрэгжүүлэх дээр нь одоо яаж тогтоох вэ? Нэгдсэн чуулганаар энэ асуудлыг оруулдаг байх нь, жишээлбэл Байнгын хорооны хяналт шалгалтын ажлын үр дүн бас гарах ёстой гээд би үзэж байгаа юм. Тэгээд энэ дээр бас ажлын хэсгийн ахлагч тухайн ажлын хэсэг дээр хэлж байсан л даа. Жишээ нь Байнгын хорооноос гарсан тэр хяналт шалгалтын ажлын тогтоолыг бид Засгийн газраас чиглэл болгодог бол үүнийг жишээ нь чуулганы хуралдаан дээр юм уу асуудал болгоод тавьдаг. Магадгүй түр хороо нь нээлттэй сонсгол энэ асуудлаар явуулдаг энэ тэр байж байж үр дүнд хүрнэ л дээ. Тэгэхээр энэ тал дээр бас тодорхой яаж заалт орсон бэ? Энэ дээр би хариулт авъя аа гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар.

**Ж.Сүхбаатар:** Энэ хууль маань Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу гарч байгаа хууль гэж хэлж болно. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа болбол энэ хянан шалгах түр хороо байгуулах, ер нь Улсын Их Хурал, засгийн газрын эрх мэдэл хоорондын эрх мэдлийн хуваарилалтыг хийж, Улсын Их Хурлын төсвийн томилгооны шинжтэй нэлээд эрхүүд хумигдсан. Ер нь бол парламентын хөгжлийн шатанд болбол Улсын Их Хурал, Засгийн газар бол эрх мэдлээ зохистой хуваарилахын хувьд нэг талдаа хумирахаас гадна нөгөө талдаа бас чиг үүрэг гэж нэг тодотгох шаардлага үүссэн. Өөрөөр хэлэх юм бол Монгол Улсын Их Хурал бол тодорхой одоо эрхүүд хязгаарлаж, Засгийн газар, Ерөнхий сайдын эрх мэдлийг хүчтэй болгож, хуулийн гүйцэтгэлийг, амьдрал дээрх одоо бодит биелэлтийг хангах тэр боломжоор хангаж өгөхөөс гадна бидний сүүлийн хэдэн жилд яригдсан хууль олноор үйлдвэрлээд байна аа. Одоо ажлын хэсэг байгуулж, ор нэр төдий хяналт тавьдаг. Улсын Их Хурлын хяналт шалгалт болбол одоо хэлбэрийн төдий тодорхой шүүмжлэлүүд дээр бол өртөж байсан. Ийм байгаа учраас Улсын Их Хурал бодлого гүйцэтгэл, хууль үр дүн яг гэсэн энэ одоо чиглэлээр бол хяналт шалгалтынхаа чи үүргийг олон улсын хэмжээнд аваачиж, Монгол Улсын энэ парламентын хөгжил бол танин мэдэхүйн шатнаас дараачийн хуулийн биелэлтийг хянан шалгадаг, араас нь явдаг цөөн тооны хууль гаргаад, тэгээд хуулиудаа гарцаагүй биелүүлдэг ийм одоо чанар байдлын энэ чиглэл рүү орох үүднээс бол энэ хууль гарсан.

Хуулийн онцлог зохицуулалтуудыг товчхон хэлэх юм болбол хяналт шалгалтын мэдээллийн Улсын Их Хурал нэгдсэн сантай болно оо. Хяналт шалгалтын мөрөөр одоо арга хэмжээ авч, хариуцлага тооцдог болно оо. Хууль тогтоомжуудыг засаж сайжруулдаг болно. Байнгын хороод, хууль тогтоомж дээр анализ, дүн шинжилгээ хийлгэх Тамгын газрын чадавхыг одоо хүчтэй болгосноор бол Байнгын хороодын чадавх, чадамж бол дээшилнэ. Байнгын дэд хороо хянан шалгах бүрэн бүрэн эрхээ бол цэгцтэй хэрэгжүүлж эхэлнэ. Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнадаг тогтолцоо үүнийг дагаж бий болно. Парламентын үл хүндэтгэж байгаа үйлдлүүд дээр хариуцлага хүлээлгэдэг байдал гарцаагүй болж эхэлнэ. Арга хэмжээ авах тэр улсууд дээр бол Улсын Их Хурал тогтоол шийдвэр гаргаад бодитойгоор, бас Засгийн газарт тавих хяналт болбол ингэж сайжрах юм байгаа юм аа. Асуулт асуулгын ялгаануудыг бид нар тодруулсан байж байгаа.

Хамгийн гол чухал юм бол Улсын Их Хурлын энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх чадавхыг болбол бид нар их дээшлүүлнэ. Энэ Тамгын газрын чадавхыг дээшлүүлснээр болбол Байнгын хороодын чадамж дээшилж, Улсын Их Хурлын хянан шалгах энэ бүрэн эрх болбол нэлээн хугацаагаар дээшлэх юм.

Дээр нь болбол сонсголын энэ механизм байгаа. Манайх бол одоо өнгөрсөн хугацаанд 7 удаа хяналтын сонсгол хийсэн. Нийтийн сонсголын хууль 2015 оноос батлагдсанаас хойш. Тэгэхээр бид сонсголоо нэлээн нарийвчилсан, төрөлжүүлсэн. Сонсголдуудыг хийснээрээ болбол Улсын Их Хурлаас томилогдож байгаа бол зөвшилцөж байгаа, танилцаж байгаа энэ субъектүүдийн үйл ажиллагааг бол олон нийтийн шүүлтүүрт оруулах боломжийг болбол бий болгож, олон нийтийн хяналт, оролцоог бий болгож байгаа. Энэ хянан шалгах хууль гарснаар болбол бид нар хянан шалгах түр хороо гэдэг энэ одоо маш чухал механизмыг олон улсын хэмжээнд бол парламентын мөрдөн шалгалт гэж ярьдаг. Зүгээр манай ажлын

хэсэг болбол яг одоо бид нарын бусад мөрдөн шалгах байгууллагатай давхцах учраас энэ нэр томъёог бас яг авч хэрэглэхгүйгээр өөрчилье гэж санал оруулж байгаа. Гэхдээ агуулга нь бол одоо хойд хөрш ч гэсэн 2005 онд л парламентын одоо парламентский ареследование гээд энэ парламентын мөрдөн шалгах зохицуулалтаа аль хэдийн хийчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр бид энэ хууль дээр болбол хууль санаачлагчийн оруулсан үзэл баримтлалын хүрээнд энэ хянан шалгах түр хороог явал бид шинээр амьдруулах вэ гэдэг тэр Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг. Энэ талаас нь бол холбогдох зарчмын зөрүүтэй саналуудыг та бүхэнд бас оруулсан байж байгаа.

Ер нь энд бол олонхын цөөнхийн одоо харилцан тэнцвэрт үйл ажиллагааг, бас энэ дотоод балансыг анх удаа одоо бас энэ ярилцлага энэ хуулиар болбол оруулахыг хичээсэн. Зарим шүүмжлэлүүд гарсан, зарим нь цөөнх нь хэт одоо эрх мэдэлтэй болж байна, эсвэл олонх нь ч гэдэг юм уу, бид бол балансыг нь бол аль болохоор нэг онцлогоо харгалзаж тус ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Одоо эрхэм гишүүн Жигжидийн Батжаргал.

**Ж.Батжаргал:** Хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй танилцсан. Энэ уул нь их гол хууль юм шиг байгаа юм аа. Би тэгж ойлгоод байгаа юм. Ерөөсөө Их Хурлын анхаарах ёстой асуудал бол энэ гаргасан хууль тогтоомжууд амьдралд хэрхэн нийцэж, тэр үйл явцаа хэрхэн дэмжиж байгаа юм бэ, саад чөдөр болж байгаа юм нь юу юм бэ гэдэг юмаа нэлээн сайн мониторинг хийх ёстой юм. Тэгж бид энэ эрх зүйн шинэтгэл боловсронгуй болгох асуудлыг авч явах ёстой гэж.

Хоёр дахь нь, ерөөсөө хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй байгууллагууд энэ хэрэгжилт зохион байгуулах чиглэлээр ямархуу арга хэмжээ авч, ямар үр дүн, үр өгөөж бий болгов гэдэг юмыг онцгой анхаарах ёстой. Энэ 2 луу л би энэ хяналт шалгалтын хуулийн гол анхаарал, зорилго чиглэгдэх болов уу гэж ингэж бодоод байгаа юм. Гэтэл тэр түр хороо ажлын хэсгийн үйл ажиллагаа явуулаад, тэгээд дүгнэлт сандал дээрээ тулгуурлаад тогтоолын төсөл боловсруулах тухай юм орж ирээд байгаа юм аа. Тэгэхээр би бол шаардлагатай тохиолдолд тэр хуулийн төсөл гэдэг юм уу, шийдвэрийн төсөл юмнуудаа давхар боловсруулаад тэр холбогдох Байнгын хороо, Их Хурал руугаа оруулж ирдэг байдлаараа байх юм бол энэ цаг хугацаа алдахгүй энэ чиг үүрэг чинь хэрэгжээд явчих бололцоо, боломж бүрдэх юм биш үү гэсэн ийм санал байгаад байгаа юм.

Хоёр дахь зүйл. Бид энэ хөгжлийн баримт бичгүүдийн нэр төрөл, болгоноор нь тайлагнал тайлагналыг хэрхэн хийж, үр дүнг нь тооцох вэ гэдэг юмыг аргачилжээ. Ер нь ерөөсөө Их Хурлаас гарсан энэ бодлого, шийдвэрүүдийн хэрэгжилт, үр дүнг тооцдог ерөнхий аргачлалаараа явахгүй бол Засгийн газрынхаа үйл ажиллагааны хөтөлбөрийг, 5 жилийнхээ үндсэн чиглэлийг, жилийн хөгжлийнхөө төлөвлөгөөг ингэж үр дүнг нь тооцно, нэг бүрчлэн ингэнэ гээд бичихээр зэрэг энэ хуулийг чинь юу арай жоохон тийм зузаараад байгаа юм биш үү. Ер нь нэг ерөнхий зарчим, аргачлалаар энэ хөтөлбөр, бодлого зорилтуудын хэрэгжилт, үр дүнг тооцох тэр юмаа тогтоож өгвөл ямар вэ гэсэн нэг ийм зүйл байгаад байгаа юм.

Гурав дахь асуумаар байгаа зүйл. Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааг бид зөв явуулах ёстой, сайн хийх ёстой. Гэхдээ бас хальчихав дээ гэмээр юм харагдаад байгаа юм. Дөчин зургаадугаар зүйл дээр тэр түр хорооны эрх гэдэг юман дээр ороод ирэхээр зэрэг үндсэндээ мөрдөн шалгах байгууллагын

эрх хэмжээний асуудлууд их тусаад орчихсон юм билээ. Тэгээд тэр дөчин ес тавиараа үүнийгээ баталгаажуулчхаад байгаа юм байна лээ. Тэгэхээр үүнийг бид эргэж харж засахгүй бол болохгүй ээ. Тэгж байж ер нь бас зөв голдиролдоо эрх мэдлийн хуваарилалт гэдэг юм уу энэ юм руугаа зөв явах бололцоо, боломж нь бүрдэх байх. Бид шалгалтаар аливаа асуудал гарч ирвэл түүнийг мөрдөн шалгадаг байгууллагуудад нь албан ёсоор хүсэлт юмаа тавьж, тэндхийн санал дүгнэлт дээр тулгуурлаж асуудлыг эцэслэдэг ийм байдал юм руугаа л явах ёстой. Түүнээс энд онцгой бүрэн эрхтэй түр хороо байгуулагдаж таарахгүй ээ. Энэ яг нарийндаа бол бас боломгүй зүйл болчихоод байна аа. Үүнийг, та бүхэн маань юу гэж үзэж байна вэ гэж энэ талаас нь хармаар байгаа юм.

Дараагийн нэг асуудал бид нарын энэ хяналт шалгалтын үйл явц, цаг үеийн ажил асуудалтай холбоотой нэлээн явагдмаар юм шиг байгаа юм. Би тэгж хараад байгаа юм. Их Хурлаас батлан гаргасан энэ бодлого зорилтуудтай уялдуулаад, түүнийг хангах талаар хийж байгаа ажлыг цаг үеийн ажил асуудлуудтай холбогдуулж богино хугацаатай, тодорхой үүрэг чиглэлүүд өгөх ёстой гэж.

Дараагийн нэг асуумаар байгаа зүйл. Энэ нутгийн өрөө удирдах байгууллагын энэ их том боломжийг бид яаж ашиглах ёстой юм бэ гэж. Аймаг, сумын хурлуудтай хэрхэн хамтарч ажиллаж энэ хяналт шалгалт ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар.

**Ж.Сүхбаатар:** Зарим асуултад нь манай хууль санаачлагчаас. Бямбацогт гишүүн бодвол хөгжлийн баримт бичигтэй холбоотой асуудал дээр би хариулах байх гэж бодож байна.

Би бусад асуудал дээр, Байнгын хорооны тухайд болбол тэр нөгөө Батжаргал гишүүний хэлээд байгаа боломж бол бол нээлттэй байгаа. Бид нар бол Байнгын хороо хяналт шалгалтыг яг хийгээд явахад асуудлыг Улсын Их Хуралд оруулах эсвэл одоо би бүх л юугаар нь товчилж хэлье. Байнгын хороо бол өөрөө тогтоол гаргаж болно, Засгийн газарт чиглэл өгчхөж болно. Мөн Улсын Их Хуралд асуудал оруулчхаж болно. Мөн Байнгын хороон дээр сонсгол хийгээд хийгдээд энэ хуулийг базаад хэлэх юм бол сонсгол хийгээд тэр сонсголынхоо тайланг Улсын Их Хуралд оруулж болно. Байнгын хороо үүнээс тусдаа, яг таны хэлдгээр асуудлууд дээр өөрөө шийдвэрийн төслөө боловсруулаад Улсын Их Хурлын тухай хуулиараа ч тэр өөрөө шаардлагатай шийдвэрийн төслөө санаачлаад л бас асуудал оруулчих эрх нээлттэй байгаа. Тэгэхээр энэ асуудал болбол хянан шалгах энэ хууль гарснаар болбол улам олон сонголттой, олон варианттай болчихож байгаа олон хувилбартай.

Дараачийн асуудал дээр бол энэ түр хороон дээр дөчин зургаадугаар зүйл мөрдөн шалгах байгууллагуудтай давхцаад байна гэж. Энэ хууль дээр бол бид нар ийм мөрдөн шалгах бусад байгууллагуудад заавар өгөх, хөндлөнгөөс оролцох энэ юмыг хориглосон байгаа. Ер нь Үндсэн хуульд бол гагцхүү шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлнэ гэж заачихсан байдаг. Нөгөө талаас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд болбол энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд одоо энэ процессын дагуу бол тэр хуулийн дагуу шууд Улсын Их Хурал оролцохыг хориглочихсон. Бусад одоо этгээд оролцохыг хориглосон. Гол нь энэ хэргийн одоо оролцогч талууд л оролцохоор журамлагдсан байдаг. Энэ түр хорооны юм бол одоо бид нар цоо шинэ юм руу орж ирнэ. Тэгэхээр энэ одоо англи дээр болбол энэ парламентын мөрдөн шалгалт гээд парламент, инвест кэйшн, энквейер эд гээд

яваад байгаа юм. Оросууд бол парламентский ареследование гээд дандаа яг тэр үгээрээ болбол хууль зүйн нэр томъёогоор мөрдөн шалгалт байгаа. Парламентын мөрдөн шалгалт. Бид нар болбол энэ үгийг бол өөрчилъе гэж байгаа, таны хэлдгээр бас давхцуулаад байж магадгүй учраас энэ бол Улсын Их Хурлын тусгай шалгалт юм, онцгой биш тусгай шалгалт юм. Ер нь энэ онолын юмыг нь ярих юм бол нэлээн олон юм бий л дээ. Парламент гэдэг бол олон асуудлыг бас гүйцэтгэх мэдлийн оролцоогүйгээр шүүх эрх мэдлийн оролцоогүйгээр ард түмний төлөөлөгчдийн байгууллага. Дотоод хүрээндээ бас асуудлыг тусгай журмаар авч үздэг энэ тогтолцоо бол дэлхийн улс оронд түгээмэл байгаа юм аа. Манайх одоо парламентын хөгжлийн дараачийн шатанд орох болсон. Энэ олон асуудлууд чинь ингээд парламент дээр бас ярих юмнууд бас байна. Тэгэхгүй болохоор дүйвүүлээд, мөрдөн байцаах байгууллагын улс төр, нийгмийн асар том асуудлууд гардаг. Тэгээд тэр нь мөрдөгдөж байгаа гээд яваад байдаг. Олон нийтэд нээлттэй биш, яагаад гэвэл эрүүгийн хэрэг одоо гэмт хэргийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөх боломжгүй гэдэг. Гэтэл парламент дээр хянан шалгах түр хорооны хийж байгаа үйл ажиллагаа болбол харьцангуй нээлттэй явдаг, асуудлыг шийдвэрлэх, цаад ул сууриар нь явах энэ боломжийг олгодог юм аа. Тэгэхээр бид олон улсынхаа энэ юм руу орж хийе ээ гэж ингэж хийсэн. Ингэснээрээ давхардах тийм асуудлууд үүсэхгүй юм. Зүгээр одоо орчин үед гарч байгаа асуудлууд дээр бол парламент бол өөрөө олон түмний тэр дуулиан шуугиан тарьсан, нийтийн ашиг сонирхлыг хөндчихөөд шийдэгдэхгүй байгаа асуудлуудыг шийддэг юм байна аа гэдгийг бол харуулсан. Энэ өнгөрсөн, одоо дэлхийн улс орнууд энроны одоо хэрэг явдал Америкт ч гэдэг юм уу, Германд коллийн одоо хэрэг явдлууд ч гэдэг юм уу, энэ асуудлуудыг ердийн тийм хууль тогтоо тогтолцоогоор бол шийдэх бололцоогүй байсан. Жишээлбэл. Парламент дээр нь ингэж шалгаж байж асуудал шийдэгдэж байсан байх жишээтэй.

Нутгийн удирдлагын боломжийг ашиглах ёстой. Одоо засаг захиргаа, нутгийн дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль ингээд ирэх нэг сарын нэгнээс хэрэгжинэ ээ. Энэ хуулийн дагуу бол нутгийн, одоо бүх одоо сум, дүүрэг, аймгийн нийслэлийн төлөөлөл болсон ийм мэргэжлийн том холбоо, хүчирхэг холбоо бий болно. Тэр холбоо Улсын Их Хурал, Засгийн газартай хамтран ажиллана. Байнгын хороод, нутгийн удирдлагын дэд хороо бас энэ дээр анхаарал тавина.

Хянан шалгах хорооны тухайд нутгийн удирдлагын асуудлууд дээр өөр боломжуудыг нэмж тусгана аа гэвэл бид нар одоо бэлэн байна, гэхдээ яг одоогийн тухайд энэ дээр бол хориглогдсон ч юм уу, тэр боломжийг хаачихсан юм уу, ямар ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Батжаргал гишүүний асуултад хариулъя аа. Урьд нь Улсын Их Хурлын хяналт шалгалт гээд асуулт тавих, гишүүд асуулга асуух, за дээрээс нь тайлан мэдээлэл сонсох гэсэн ийм гурван хэлбэртэй байсан. Энэ гурван хэлбэр дээр нэмээд бид нар асуултаа тавина, асуулгаа тавина, хууль тогтоомжийн хэрэгжих үр дагаварт үнэлгээ хийнэ. Мөн одоо төсвийн хяналт хийнэ. Хяналтын сонсгол хийх, хянан шалгах түр хороо байгуулах гэсэн ийм 7 хэлбэрийн хяналтыг Улсын Их Хурлаас тавьдаг болохоор болж байгаа Үүнийх нь нэг хэлбэр болбол тайлан мэдээлэл сонсох, тэгээд энэ дээр бол хуучин болбол бид нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, төсвийн гүйцэтгэл, жил бүрийн үндсэн чиглэлийн биелэлт гээд ингээд юмнууд хэлэлцдэг энэ дээр үндсэндээ бол

хоорондоо уялдаа холбоогүй, хуучнаар одоо юу гэж хэлдэг юм, нөгөө еэвэнгийн тал нь хаа байна гэхээр энэ байна гээд л нэг харуулчихдаг. Нөгөө тал нь хаачсан юм гэхээр энэ байна гээд харуулчихдаг. Ийм байдлаар бодлого, зорилгоо их сайхан тодорхойлчихдог. Түүнийгээ хэрхэн яаж зохион байгуулж, хэрэгжүүлж байна гээд хянах гэхээр хянах боломжгүй. Төсөв мөнгөний бодлого нь хоорондоо уялдаагүй, үндсэн чиглэл, төсөв хоёр нь хоорондоо уялдаагүй. Эргээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл хоёр нь хоорондоо уялдаагүй, дунд хугацааны бодлого, богино хугацааны бодлого гээд ярих юм болбол. Ийм байсан учраас бид нар одоо хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд орсон үндсэн одоо 5 бичиг баримт болох улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн 7 зорилтот хөтөлбөр, урт хугацааны алсын хараа гэж, тийм үү. Энэ бодлого байж байгаа. Энэ бодлогуудын уялдаа холбоог хэрхэн яаж хангаж байна гэдгээр нь нэгдүгээрт нь Улсын Их Хурал хяналт шалгалтаа хийж байх ёстой.

Хоёрдугаарт нь энэ бодлогуудыг хэрхэн яаж уялдуулж, хэрхэн яаж тийм үү зохион байгуулж урт, дунд, богино хугацаанд салбар хооронд, бүс нутаг, үндэсний хэмжээнд зохион байгуулж биелүүлэв ээ гэдгийг нь гүйцэтгэлийнх нь тайланг сонсож байх. Ингэж явахгүй болохоор нөгөө еэвэнддэг болчихсон. Тал нь хаана байна гэхээр энэ талд байна, нөгөө тал нь наана байна гэхээр энэ тал дээр гээд. Ийм байгаад байдаг хуучны алдааг давтагдуулахгүйн тулд энэ одоо тийм, энэ тавьсан зорилго, зорилтоо хэрхэн яаж уялдуулж байна, уялдаа холбоо хэрхэн яаж хангагдаж байна, тэгээд дараад нь уялдаж байгаа болбол түүнийгээ хэрхэн зөв зохион байгуулж, зөв хэрэгжүүлж, үр дүнг нь тооцож чадаж байна аа гэдэг дээр одоо хянадаг байхын тулд энэ хяналт шалгалтын тайлан мэдээлэл, илтгэлийг сонсоно оо. Тайлан мэдээлэл бэлтгэх сонсохдоо зөвхөн одоо хөгжлийн бодлоготой холбоотой асуудал ийм байдлаар уялдуулна. Бусад байдлаар бол 12 төрлийн мэдээллүүдийг Их Хурлаас сонсдог байхаар тайлан, энэ дээр болбол яаж тайлан мэдээлэл илтгэл сонсоно хэлэлцэнэ гэдэг байдлаар таниулж оруулсан байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууна аа.

**Ж.Батжаргал:** Таны хариултууд дээр тулгуурлаад 2 зүйлд тодруулах зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр тайлан мэдээлэл сонсох, барих энэ бүх үйл ажиллагааг бол дэмжиж байгаа зөв. Гэхдээ бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, таван жилийн үндсэн чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөө энэ тэр гээд нэр заагаад, тэгээд дор нь яг ингэж ингэж гээд заачхаад байгаа байхгүй юу. Тэгээд түүнийг базаад нэг л одоо аргачлалаар л явчихмаар санагдаад байгаа юм. Би бол тэгж ойлгоод танаас асуугаад байна л даа.

Тэгэхээр үүнийг бид ингэж анхаарвал ер нь ямар вэ гэж. Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлууд, ерөөсөө энэ Монгол Улсын мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах, өөрийнхөө гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах чиглэл дээр энэ хяналт шалгалтын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд явуулаад байгаа юм аа. Тэгэхээр энэ байгууллагуудыг зөв арга зүй чиглэлээр нь хангаад улсын хэмжээнд зарим асуудлуудыг ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн асуултад хариулна аа.

**С.Бямбацогт:** Бид нар сүүлийн 30 жилийн хугацаанд нөгөө төлөвлөлт гэдэг юмыг мартчихсан. Тийм болохоор энэ төлөвлөлтийн соёл төлөвлөснийгөө, тийм үү, эргүүлээд тайлагнадаг соёл гэдэг юм нь бас хаягдчихсан. Тийм учраас бид нар ингээд тийм урт дунд, богино хугацаандаа уялдуулж төлөвлөө өө, төлөвлөснийгөө тийм үү хэмжиж үнэлж дүгнэж тайлагнадаг байя аа. Ямар зорилт тавьсан юм, яаж хэрхэн яаж хэрэгжив энэ чинь хоорондоо уялдсан юм уу, уялдаагүй юм уу хэдэн хувьд нь хүрэв. Одоо Засгийн газрын үйл ажиллагааны улсын төсөв бид нар баталлаа. Улсын төсөв батлаад энэ батлагдсан төсөв хэрэгжихэд үндсэндээ 2022 он дуусахад Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 60 хувь нь биелсэн байх ёстой. Гэтэл бид нар улсын төлөвлөгөө, төсөв хоёр маань хэрхэн уялдав. Төсөв маань хэрэгжээд дуусахад төлөвлөгөө маань бүрэн биелж чадах уу, чадахгүй юу гэдгээ хооронд нь уялдуулж, үнэлж дүгнэж одоо чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Тийм болохоор бид нар энэ урт, дунд, богино хугацаа хооронд нь уялдуулах, төсөв, төлөвлөгөө маань хоорондоо уялдаж байх энэ соёлыг бий болгох үүднээс заавал одоо энэ хяналт шалгалт ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Одоо эрхэм гишүүн Ширнэнбаньдын Адьшаа асуулт асууна.

**Ш.Адьшаа:** Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая аа. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг өнөөдөр Улсын Их хурал хэлэлцэж байна аа. Энэ хууль бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу хийгдэж байгаа парламентын засаглалын үйл ажиллагааг төгөлдөржүүлэх, Парламентын засаглалын хууль дээдлэх зарчим, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, энэ асуудлыг шинэ шатанд гаргахаар зорьж байгаа хууль байгаа учраас энэ хуулийг батлахыг зарчмын хувьд дэмжиж байгаа юм аа.

Гэхдээ хууль санаачлагчдаас зарим зүйлийг тодруулах шаардлагатай байна аа. Энэ хуульд Улсын Их Хурлын хяналт, шалгалтын түр хороо байгуулж, тэр түр хороо нь өнөөдөр мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах ийм үндсэн санааг энэ хуульд оруулжээ. Энэ мөрдөн шалгах хороо бол өнөөдөр шүүх эрх мэдлийн асуудлыг авч хэлэлцэх, мөрдөн шалгах байгууллагуудтай адилхан үйл ажиллагаа явуулна гэвэл энэ бол өнөөдөр Үндсэн хуулийн хямрал руу оруулах, ийм үйл явцыг өргөжүүлэх ийм үр дагавартай шүү. Шүүхийн тухай хуулийг бид баталсан. Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд өнөөдөр Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо гэдэг энэ байгууллагын шүүгч бус гишүүдийг томилох, энэ үйл ажиллагаа нь Үндсэн хууль зөрчсөн асуудал байгаа. Энэ асуудлыг би цаашдаа дахин ярих болно оо.

Үүнтэй адилхан өнөөдөр мөрдөн байцаах, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг гэмт хэргийг шалгах явцад оролцдог ийм давхар санааг энэ хуульд энэ хууль санаачилж оруулахгүй байх аа гэдэгт найдаж байна. Нөгөө талаар энэ тайлан мэдээлэл сонсох гэдэг энэ энэ юмыг авч хаяа аа. Энэ хуулиас. Өнөөдөр тайлан мэдээллийг бид өнөөдөр Засгийн газрын түвшинд, байгууллагын түвшинд Улсын Их Хуралд дандаа тайлан, мэдээлэл сонсдог. Энэ тайлан мэдээлэл сонсоод түүний үр дүн гэж өнөөдөр юу ч байхгүй байгаа шүү дээ. Ерөнхий сайдын мэдээлэл, Засгийн газрын гишүүдийн мэдээлэл, Улсын Их Хурлын харьяа байгууллага мэдээлэл сонсдог. Түүнээс гарсан үр дүн гэж харахгүй байгаа. Өнөөдөр маш олон хууль баталж байна. Тэр хуулийн хэрэгжилт өнөөдөр ямар ч үр дүнгүй байна аа. Энэ асуудлыг шийдэж, энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийг баталсны үр дүн гарах байх гэж найдаж байгаа. Яагаад гэвэл өнөөдөр Засгийн газрын үйл ажиллагаа, бусад албан тушаалтнуудын хууль зөрчсөн үйл

ажиллагаа, Улсын Их Хурлаас өгсөн үүрэг, чиглэл, Улсын Их Хурлаас баталсан хуулийг хэрэгжүүлэх энэ асуудал бол өнөөдөр хэрэгждэггүй ээ. Энэ хяналт шалгалтын хуулиар өнөөдөр үүнийг хэрэгжүүлэхийн төлөө, хууль дээдлэх зарчим, хуулийн хэрэгжилтийн төлөө энэ хяналт шалгалтын хууль батлагдаж, үр дүнгээ өгнө гэдэгт би итгэлтэй байгаа юм аа.

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн Хууль зүйн байнгын хорооны дарга асуултад хариулна аа.

**С.Бямбацогт:** Тэгэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 онд хийсэн. 2019 онд хийхдээ төрийн одоо эрх мэдлийн хуваарилалтыг тэнцвэртэй болгох, энэ парламент болоод Улсын Их Хурал, шүүх эрх мэдэл энд одоо хяналт тэнцлийг бий болгох зорилгоор хийсэн. Улсын Их Хурлаас тодорхой, одоо бүрэн эрхүүдийг хязгаарласан, өөрөөр хэлэх юм бол Засгийн газрын гишүүдийг томилох, огцруулах, энэ асуудал бол Улсын Их Хурлын асуудал биш болсон. Ерөнхий сайдын бүрэн эрхийн асуудал болсон. Ийм байдлаар тодорхой төсвийн хязгаарлалтууд бас Улсын Их Хурал дээр хийгдсэн. Иймэрхүү байдлаар тодорхой бүрэн эрхийн хүүд одоо тийм үү, татгалзсан. Нөгөө талдаа бол энэ хяналт шалгалт хийх төрийн бодлого тодорхойлно, төрийн бодлого маань хэрхэн яаж хэрэгжиж байгаа дээр бодлого тодорхойлсон байгууллага нь өөрөө эргээд хяналтаа тавьдаг, үр дүнг нь тооцдог, энэ бол байх ёстой зайлшгүй зарчим гэж үзэж Улсын Их Хурлын хяналт шалгалт хийх, Улсын Их Хуралд онцгой бүрэн эрх байж байгаа. Хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх, хэрэгжүүлэх, хяналт тавих. Энэ Улсын Их Хурлын Үндсэн хуулийн хорин тавын нэг долоод заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ мөрдөн шалгах түр хороо байгуулж болно оо гэж Үндсэн хуульд 2019 онд орсон юм аа. Энэ Үндсэн хуулийг амилуулах, Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хууль маань батлагдаж байгаа. Энэ дотор бол хяналт шалгалтын хамгийн одоо том дээд хэлбэр нь болбол мөрдөн шалгах түр хороо байгуулах асуудал. Цөөнхийн төлөөллийг оролцуулаад парламентын гишүүдийн тодорхой хувь нь 19 гишүүн үзэх юм болбол энэ хороог байгуулж болно оо гэж.

Энэ дээр манай бас ажлын хэсгийн гишүүн Мөнхсайхан багш, нэмж хариулах байх. Ийм байдлаар хийсэн юм аа. Өөрөөр хэлэх юм болбол энэ хяналт, төр бодлогоо тодорхойлно, төр хяналтаа тавих ёстой. Хяналтаа тавихад нь, ялангуяа одоо бас цөөнхийг оролцуулж, хяналтаа тавьдаг байя аа. Ингэж байж тийм үү? Хүн өөрийгөө хянадаг, өөрийнхөө алдаа дутагдлыг засдаг байх ёстой. Үүнтэй адилхан төр бодлогоо хэрхэн яаж хэрэгжиж байгаад, хяналтаа тавьж байж алдааг засна аа гэдэг үүднээс оруулж ирсэн. Ингэхдээ бол таны хэлж байгаа шүүх засаглалтай, шүүх эрх мэдэлтэй болбол ямар нэгэн байдлаар одоо тийм үү, ашиг сонирхол, дээрээс нь одоо эрх мэдэл булаацалд байгаа зүйл огт байхгүй. Үндсэн хуулийн хүрээнд хязгаарт энэ асуудал шийдэгдэж явна аа. Өөрөөр хэлэх юм бол энэ тусдаа явна аа гэж та бүхэн ойлгоорой.

Тайлан, мэдээлэл хэлэлцээд одоо үр дүнгүй байна аа гэж. Тайлан, мэдээлэл бол урьд нь бол хэлэлцээд өнгөрдөг байсан. Одоо энэ хяналт шалгалтын анхдагч хууль батлагдсанаараа тайлан, мэдээлэл хэлэлцээд тодорхой шийдвэрүүдийг Улсын Их Хурал гаргах бололцоотой болж байгаа. Бололцоотой. Хууль тогтоомжийн хэрэгслийн үр дагавар үнэлгээ хийхэд хууль тогтоомжийг засах, залруулах, тайлан мэдээлэл сонсоод хангалтгүй болбол тайлан мэдээллийнхээ дагуу тийм үү, Засгийн газар болон холбогдох албан тушаалтанд

хариуцлага тооцох гэх мэтээр үе шаттайгаар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх бас бололцоо бололцоотой. Урьд нь яагаад хэрэгждэггүй тайлан, мэдээлэл сонсоод үр дүнгүй байгаад л байсан бэ гэвэл тийм механизм, хариуцлага тооцох механизм байхгүй байгаад байсан учраас үр дүнгүй, нэг асуусан болдог. Хариулсан болдог, мэдээлэл сонссон болдог, тайлан хэлсэн болдог. Энэ өнгөрөөд байсан. Одоо энэ хууль үндсэндээ хэрэгжсэнээрээ энэ Их Хурал дээр гарсан бодлого шийдвэр заавал амьдрал дээр хэрэгждэг, алдаа дутагдал байх юм бол засагддаг, асуудал үүсэх юм болбол хариуцлага асуудал үүсгэсэн, одоо алдаа гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцдог болох, энэ бололцоо боломж нь бүрэн бүрдэх юм аа.

**Г.Занданшатар:** Ширнэнбаньдын Адьшаа гишүүн тодруулж асууя. Нэг минут.

**Ш.Адьяа:** Бямбацогт даргын тайлбарыг сонслоо л доо. Тэгэхдээ андуурч хэлээгүй байх аа гэж найдаж байна. Хяналт шалгалтаар төрийн бодлогыг тодорхойлно гэдэг чинь юу гэсэн үг юм бэ? Бямбацогтоо. Хяналт шалгалтаар төрийн бодлого тодорхойлно гэдэг ийм юм байж болохгүй ээ. Бид нар бол парламентын засаглалтай, төрийн тогтолцоо чинь ямар билээ. Ийм байдлаар асуудалд хандаж болохгүй ээ.

Хоёрдугаарт нь тэр мөрдөн шалгах түр хороо гэдэг энэ асуудал бол өнөөдөр хууль, шүүхийн байгууллагын хийх ажилтай хутгалдахгүй байх гэсэн ямар баталгаа байна. Өнөөдөр би яриад байгаа шүү дээ. Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хараат бус гишүүдийг томилох асуудал дээр үнэхээр хууль дээдлэх зарчмыг алдагдуулсан асуудлын тухай л би яриад байгаа юм. Улсын Их Хурлын гишүүн бол өнөөдөр хууль тогтоодог, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаг л ийм үнэ ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Ажлын хэсгээс гар өргөж гэж байна. Эхлээд Сандагийн Бямбацогт гишүүн, дараа нь 82, ажлын хэсэг Мөнхсайхан доктор.

**С.Бямбацогт:** Тэгэхээр та түрүүн асуухдаа бол тайлан, мэдээлэл сонсох огт хэрэггүй гэж ярьснаа. Тайлан мэдээлэл сонсох маш чухал. Одоо дэмжиж байна гээд ярьж байна л даа. Яг тэрэнтэйгээ асууж байгаа асуултаа өөрөө үгүйсгэж байгаатай адилхан сая асуулт асуучихлаа. Төрийн бодлогыг Улсын Их Хурал тодорхойлдог юм аа. Төрийн бодлогын хэрэгжилтэд Улсын Их Хурал хяналт тавьдаг юм аа. Үндсэн хууль та уншаарай. Үндсэн хууль дээр ингээд заачихсан. Энэ хүрээндээ бид бодлогоо тодорхойлно, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих юм аа. Бид хууль тогтоох, хууль санаачлах эрхээ эдэлдэг мөртөө сүүлийн 30 жил хяналт тавих үүргээ биелүүлж чадахгүй ирсэн. Тийм учраас энэ хяналт тавихын тулд Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан үүргээ биелүүлэхийн тулд л энэ хуулийг санаачилж, одоо бид баталж байгаа. Энэ үүргээ биелүүлдэг болох гэж байгаа юм аа, зөв ойлгоорой.

**Г.Занданшатар:** Хууль хэрэгждэггүй гэсэн яриа ард түмний дунд байгааг л. Хуулийн хэрэгжилтийн хяналт, 82, ажлын хэсэг Мөнхсайхан доктор хариулна.

**О.Мөнхсайхан:** Тэгэхээр 2010 онд Үндсэн хуулийн эх баригч Чимид багш энэ хүн парламентын хяналт гээд том судалгаа хэвлүүлсэн. Энэ дээрээ одоогийн тухайн үеийн Их Хурал болбол олон улсад байдаг парламентын мөрдөн шалгалт гэсэн энэ функцийг хэрэгжүүлэхгүйгээс болоод ажлын хэсэг нэртэй, ийм нэр төдий

одоо хяналт шалгалтаа явуулаад, тэгээд нөгөө баталсан хуулийн хэрэгжилт болбол байхгүй байна аа. Энэ нь өөрөө хууль тогтоох ажиллагааны маш чухал хэсэг нь алдагдсан байна аа, тийм учраас ийм түр хороо байгуулах тодорхой бүрэн эрх өгөх тухай ийм үндэслэлийг бол бас анх гаргаж тавьж байсан.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 28.2-т энэ хянан шалгах түр хороог байгуулахаар заасан. Энэ дээрээ болбол нотлох баримт гаргуулах, гэрчээр дуудах, шинжээч томилох гэсэн ийм бүрэн эрхтэй байхаар төсөл өргөн баригдсан. Хэлэлцүүлгийн явцад энэ бүрэн эрхийг тусгайлсан хуулиар болбол тогтоож өгнө өө гэж ойлголцоод хууль дээр тусгана гэж баталсан байгаа. Тийм учраас 2020 оны хоёрдугаар тогтоол дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын дагуу сая дурдсан бүрэн эрхүүдийг олгох ийм хуулийг болбол батлахаар энэ үзэл баримтлалыг нь тогтоож өгсөн. Тэгээд үүний цаад шалтгаан нь болбол шүүх, мөрдөн шалгах байгууллагын ажил руу хутгалдаж орох биш, харин ард түмний төлөөлөл болсон парламент нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар үнэн бодитой мэдээлэл дээр тулгуурлаж хэлэлцүүлэг явуулах, түүн дээрээ үндэслэж шийдвэр гаргаж тухайн асуудлыг шийдвэрлэх, иргэдийн мэдэх эрхийг хангах ийм зорилготой. Энэ бүрэн эрх бол одоо парламентын засаглалтай ийм мөрдөн шалгах хороотой бүхий л улсуудад болбол байж байгаа. Тэгэхдээ сая Адьшаа гишүүний хэлдэгтэй адилхан ийм эрсдэл үүсэхээс сэргийлсэн маш олон зохицуулалтуудыг энэ төсөлд тусгаж өгсөн байгаа.

Нэгдүгээрт бол төслийн дөчин дөрвийн аравт, хууль шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд саад учруулахгүй, хөндлөнгөөс оролцохгүй заавар чиглэл өгөхгүй гэдгийг маш тодорхой байдлаар энэ түр хороон дээр хориглож өгсөн.

Хоёрдугаарт дөрвийн хоёрын гурав дээр бол шүүх, гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг бол орлон гүйцэтгэхгүй ээ гэсэн ийм байгаа юм. Дээрээс нь энэ дээр гэрчээр дуудагдаж байгаа этгээдийн хувьд, жишээ нь өөрөө гэмт хэрэг үйлдсэн нь буруутгагдах юм уу яллагдагчаар татагдсан тохиолдолд гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах, мөн мэргэжлийн үйл ажиллагааны нууцтай холбоотойгоор мэдүүлэг өгөхөөс татгалзах ийм боломжийг нээж өгсөн. Тэгэхээр энэ маань бол дэлхийн одоо 70-аад улсуудын парламентад байдаг, тэр жишгээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд орж ирсэн. Яг үзэл баримтлалаараа болбол явж байгаа юм аа.

Тэгээд энэ түр хороо байгуулагдсанаар бол шүүхийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурорын байгууллагын үйл ажиллагааг бол ерөөсөө эрхлэн хэрэглэхгүй. Сая дурдсан гурав дөрөвхөн ийм тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаа юм. Нотлох баримтыг гаргуулж авах, гэрчээр дуудах, гэрчийн мэдүүлэг авах, шинжээч томилох гээд. Тэгэхээр энэ нь бол Их Хурлын одоо тухайн хуулийн биелэлт нь өөрөө ямар хэрэгжиж байгаа юм бэ гэдэг дээр үнэн бодитой мэдээлэл авахад л чиглэсэн. Ялангуяа гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд болбол нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар бүх мэдээллээ парламентад гаргаж өгдөггүй. Тийм учраас парламент яг юу болоод байгаа юм, хууль яагаад хэрэгжихгүй байгаа юм, нийтлэг эрх ашиг яагаад зөрчигдөөд байгаа юм бэ гэдэг мэдээлэл авч чаддаггүй. Тийм учраас сүүлийн одоо хоёр зуугаад жил болбол энэ олон улсын парламентууд энэ бүрэн эрхийг парламентдаа өгөөд зохистойгоор өгөх замаар тэр мэдээллийг гаргаж авах, ил хэлэлцэх түүн дээрээ үндэслээд тэр хууль шийдвэрээ гаргах боломжийг олгож байгаа. Үүнийгээ ил хэлэлцэж байгаа учраас, бас иргэдийн мэдэх эрхийг хангаж байгаа юм аа гэсэн ийм одоо

шалтгаанаар бол энэ өөрөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу явж байгаа процесс.

Дээрээс нь энэ хуулийн маш онцлог бол та бас харж байгаа байх. Энэ хянан шалгах түр хороо ажиллах бүх үндэслэл журмыг маш нарийн хуульчилж өгч байгаа юм. Хэн яаж санаачлах юм, нотлох баримтыг яаж цуглуулах юм, одоо ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Адьшаа гишүүн 1 минут.

**Ш.Адьяа:** Мөнхсайхан багшийн тайлбарт хүндэтгэлтэй хандаж байна аа. Гэхдээ өнөөдөр энэ англи саксоны Ром, Германы энэ төрийн тогтолцооны онолын энэ юмыг энэ хутгаж яриад тэгээд өнөөдөр ингээд мөрдөн байцаах байгууллага, шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд хутгалдах уу гэсэн ийм нэг юм ярьсан атлаа Улсын Их Хурал шинжээч томилно, гэрчээр байцаана гэдэг чинь юу гэсэн үг юм бэ? Энэ дээр би Мөнхсайхан чамаас асууя. Ингэж бас болохгүй шүү, дүү. Өнөөдөр энэ Үндсэн хуулийн онолын одоо эрдэмтэн байж болно оо. Тэгэхдээ өнөөдөр ийм асуудлыг төрийн эрх мэдлийн, шүүх эрх мэдлийн асуудлыг өнөөдөр энэ парламент дээр ирж ингэж ярих нь одоо надад их сонин санагдаж байна аа. Энэ талаар тайлбар авъя аа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүн Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Адьшаа гишүүний яриад байгаа юмыг ойлгож байгаа. Бид нар энэ талаар бас Байнгын хороон дээрээ ярьсан, ажлын хэсэг дээр ярьсан тэгээд энэ заалт байгаа. Та дараа нь яг тэр заалт дээр нь очихоор нь дахиад тодруулаад асууж болно. Жишээ нь, дөрвийн хоёрын гурав гээд заалт байж байгаа. Түүн дээр бид нар ер нь энэ төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрийг баримтлах зарчим гэж юу юм бэ гэдгийгээ бас энэ хуульд зориуд бичээд энэ төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцлийг алдагдуулахгүй байна аа. Гүйцэтгэх шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй байна аа гээд заачихсан байж байгаа юм. Бүр. Тэгээд одоо таны санаа зовоод байгаа жишээ нь тийм юмнууд бол энд гарахгүй л дээ, гаргахгүй. Хуулиараа ингээд бид нар зориуд бүр энэ дээр ингээд бичээд өгч байгаа юм. Тэр байтугай ажлын хэсгээс гарсан санал яах вэ, Байнгын хороон дээр уначихсан юм. Тэгэхдээ та нар яг тэр саналыг хураахад нь бас бодолцоно биз. Яг таны яриад байгаа энэ зүйлүүдийг маш тодорхой болгоод зөвхөн одоо ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Нямаагийн Энхболд гишүүн гүйцээж хариулъя.

**Н.Энхболд:** Хууль тогтоох, гүйцэтгэх шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй байх гэж ерөнхий бичсэн байсныгаа одоо яг таны санаа зовж хэлээд байгаа шиг энэ хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр, тагнуул, прокурор зэрэг байгууллагын хуулиар тусгайлан тогтоосон чиг үүргийг орлож хийхгүй ээ гэдэг санаа нь бас уг нь тодруулж оръё гэсэн ийм санал бас явж байгаа. Тэгээд түүн дээр та бүхэн саналаа хэлнэ биз.

Магадгүй зүгээр гэрч гэхээр нөгөө бид нар гэмт хэрэгтэй бусад цагдаа, хуулийн байгууллагуудын оролцоотой хийгддэг тэр ойлголтоор нь ойлгоод байж магадгүй. Гэхдээ одоо ч гэсэн бид нар Улсын Их Хурал дээр ямар нэгэн байдлаар асуудал тавиад хариулт авахдаа үндсэндээ тэр хүмүүсийг гэрчээр гэдэг үг нь чухам ямар байдаг юм байгаа юм, бас яг л адилхан дуудаж авчраад л асуугаад л

энэ ямар учиртай яагаад ингэсэн юм тэгсэн гээд ярьж байгаа юмнууд байгаа шүү дээ. Хамгийн гол нь тэр байгууллагуудын хийдэг юмнуудыг бид нар энд хийхгүй гэдгээ хуульдаа нэг зааж өгч байгаа. Тэр ч байтугай төсөл дээр орж ирсэн байсан. Одоо жишээ нь мөрдөн шалгах арга хэрэгслээр гэсэн үг юмнуудыг бид нар Байнгын хороон дээр ярьж байгаад хасчихсан байж байгаа. Яг ийм асуудал гарах болов уу гэж бодоод. Тэгэхээр санал хураах явцад энэ дээрээ бас та бүхэн дахиад тодруулаад асуугаад саналаа өгөөд явж болно байх аа гэж бодож байна.

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Балжиннямын Баярсайхан

**Б.Баярсайхан:** Баярлалаа. Энэ хууль бол маш чухал хууль байгаа. Монголд ер нь бол хууль бол хангалттай байгаа. Үүнийг дагаад гардаг, зохицуулалт нь ч гэсэн харьцангуй боломжийн гэж хардаг. Гагцхүү хуулийн хэрэгжилт нь шат шатандаа хангалтгүй байна аа гэдгийг бол бүх нийтээрээ үүнийг мэдэж байгаа. Чимэд багшийн нэг хэлсэн сайхан үг байдаг. Улсын Их Хурал нь сайн хууль батлаад, Засгийн газар нь сайн хэрэгжүүлээд, ингээд хууль шүүхийн байгууллага нь шударга ажиллах юм бол сайхан нийгэм бий болно оо гэж. Бид нар энд хэчнээн сайхан хууль батлаад яг хэрэгжилт дээрээ очоод энэ хэрэгжихгүй болбол өнөөдөр Улсын Их Хурал ингэж одоо ажиллаад ч яах юм бэ гэсэн ийм бодол төрдөг өө.

Амьдрал дээр ингээд харахаар хуулийн дагуу хяналт шалгалт хийгээд байх юм. Зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгөөд байдаг ч зөрчлийг яаж арилгасан талаар ямар ч одоо эргэх холбоо байхгүй, эргэж шалгадаггүй асуудал байна.

Хоёрдугаарт асуудал, зөрчлийг заавал гомдлоор тодорхойлдог, гомдол гараагүй л бол асуудалгүй гэж хайрцагласан сэтгэхүйтэй ийм хандлага бол орон нутагт, ялангуяа маш их байна аа. Асуудал ярихаар гомдол гараагүй болохоор гэдэг одоо хариугаар ам таглаж байна.

Гуравдугаарт, гомдол гарсан ч гэсэн түүнийг одоо бүрэн шаардлагын хэмжээнд хүртэл шийдвэрлэдэггүй орхидог. Танил талаа хамгаалаад мартуулдаг, хариуцлага тооцдоггүй, нөгөө гомдол гаргасан хүмүүс нь залхаад урам нь хугараад ингээд орхидог асуудал их байна.

Дөрөвдүгээрт нь энэ үгсэн хуйвалдаж ашиг сонирхлын бүлэг үүсгэж төрийн ажилд ханддаг, дарга цэргээр яриулдаг, танил талаар хэлүүлдэг. Ингээд замхруулдаг асуудал байна.

Өнөөдөр Улсын Их Хурал, Монгол Улсын 2022 оны төсвийн хуулиа баталлаа. Тэгээд түрүүн ярьж байна л даа, Засгийн одоо 4 жилийн хөгжлийн хөтөлбөртөө жилийн төлөвлөгөөндөө хяналт тавина гээд. Хамгийн гол нь бид нарын одоо хяналт тавих энэ ажил болбол төсвийн хууль байгаад байгаа юм аа. Төсвийн хуулийн хэрэгжилтэд Үндэсний аудитын газар нь хяналтаа тавиад зөвлөмжөө гаргадаг боловч энэ зөвлөмжийг хэрэгжүүлэх тогтолцоо нь өнөөдөр байхгүй байсаар маш олон жил болсон. Тэгэхээр одоо энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд энэ тогтолцоо яг бүрэн үндсээрээ бий болох уу гэдэг асуултыг би асууж байна. Өөрөөр хэлбэл төсвийн хуулийн хэрэгжилтэд тавьсан аудитын хяналт шалгалт, түүний зөвлөмж нь эргээд хариуцлага тооцдог тэр тогтолцоог бий болгож болох уу? Төсвийн хуульд ямар нэгэн байдлаар хариуцлагагүй хандсан этгээд болоод улсыг хохирол хохироож байгаа энэ асуудал жил жилдээ одоо засагдаад явах энэ боломж үүсэх үү? гэсэн ийм асуулт байна.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ. Ажлын хэсгийн дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Баярсайхан гишүүний асуулт бол чухал л даа. Ер нь бол хуулийг зайлшгүй биелүүлдэг гол нөхцөл нь юу юм бэ гэхээр зэрэг хянан шалгадаг. Энэ ер нь энэ хууль биелж байна уу үгүй юу гэдгийг хянан шалгахын тулд дүн шинжилгээ хийдэг, тэр түрүүний хэлдэг, тэр элдэв нотлох баримт цуглуулдаг янз янзын арга хэрэгслүүд байдаг. Хянан шалгасны эцэст яах вэ гэж. Түүний дараа хоёр арга зам байдаг. Өмнө нь гаргасан шийдвэрээ нэг бол одоо засаж сайжруулах юм байвал засаж сайжруулдаг, эсвэл шинээр шийдвэр, нэмэлт шийдэл хэрэгтэй бол шийдвэр гаргадаг. Бүр тэр зүй зохисоороо яг хэрэгжиж байгаа тэр юман дээр үнэхээр тэр санаатайгаар гэдэг юм уу, зориуд биелүүлээгүй улсуудад бол хуулийн албадлага хэрэглэдэг, эрх зүйн албадлага. Тэгэхээр хариуцлага. Түрүүн Бямбацогт даргын хэлээд байгаа тэр хариуцлага гээд байгаа шүү дээ. Гаднын улс орнуудад энэ парламентын үйл ажиллагааны гол одоо хариуцлага нь юу юм бэ гэхээр Засгийн газарт тавьж байгаа энэ хяналт, түүнийг дагалдсан хариуцлагын асуудал байгаа. Худлаа, жишээлбэл мэдээлэл парламентын танхимд хэлэх юм бол одоо бид нарын энэ хуулиар чинь бол төрийн албаны хуульд заасан хариуцлага, тэр эрүүгийн хариуцах зөрчлийн хуулийн юмнаас гадна тэр эрүүгийн хариу хариуцлага хүлээхээр хүртэл заачихсан байж байгаа. Дээр нь бас Төрийн албаны хуулиар албан тушаалаас нь чөлөөлөх гэдэг юм уу. Тэгэхээр бид энэ хянан шалгах тухай хуулийнхаа араас дандаа юу хийсэн бэ гэхээр Байнгын хороо ч тэр, энэ хянан шалгах түр хороон дээр ч бай, нэгдсэн хуралдаан дээр ч бай, дандаа хариуцлага хүлээлгэх асуудлуудыг дагалдуулж хийчихсэн байж байгаа. Одоо жишээлбэл та бид нарын асуулт асуулга дээр хугацаа хожигдуулаад өгдөг шүү дээ. Гишүүд. Гишүүд ингээд асуулт тавьчихдаг асуудал. Одоо тэгвэл бүр хугацаа хожимдуулах юм бол тэр үйлдэлд нь Төрийн албаны хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гээд заачихсан. Ингээд өмнөхөө бодвол бид бүр асуултаасаа эхэлж байгаа шүү. Асуултаасаа эхлээд л хайнга хандаад л, хожимдуулахад л, ингээд л байх юм болбол чи хариуцлага хүлээнэ ээ гээд.

Тэгээд Улсын Их Хуралд яах юм бэ гэхээр бүр том утгаараа Засгийн газарт, ингээд байхад хариуцлага хүлээлгэх асуудлаар Засгийн газар нь бусад байгууллагууд дээр тогтоол гаргана гэж байгаа юм. Хариуцлага хүлээлгэх асуудлуудаар одоо бид нарын зарчмын зөрүүтэй санал дээр хариуцлага хүлээлгэхээр тогтоол гаргана гэж ингэж өөрчилж орж ирж байгаа юм бий. Ингээд ирэхээр хүнд ерөөсөө бид нарын парламентын хийлгэдэг юм болбол хуулиа биелүүл гэж бид шаардана, шахна, хянана. Тэгээд болохгүй бол бид албадна. Албадна гэдэг нь хариуцлага хүлээлгэнэ, хариуцлага хүлээх нь албан тушаалаас чөлөөлнө, цаашлаад тэр эрүүгийн үйлдэлтэй байх юм бол холбогдох тэр үйлдлээрээ тэр холбогдох байгууллагууд нь шалгаад тэр эрүүгийн хариуцлагад татах ёстой. Энэ юм руу бол одоо эрх зүйт төрийн гол агуулга бол энэ шүү дээ. Хууль биелүүлдэг, гол дээдэлдэг соёл нь болбол юу юм бэ гэхээр тэр соёлынхоо хүрээнд юмаа биелүүлж, одоо хуулиа зохих ёсоор биелүүлж чаддаггүй, дадал чадваргүй, тийм хүмүүсийг бол зайлуулдаг шахдаг, хариуцлага хүлээлгэдэг сольдог. Энэ механизмыг болбол харин хянан шалгах энэ хуулийн одоо гол агуулга бол энэ рүү орж байгаа юм аа. Түрүүн тэр парламентын бусад улсуудын юмтай юу, яагаад байна? Янз янзын юмыг холиод байна гэж байгаа асуудал дээр болбол ерөөсөө энэ бол Германд ч бай, Оросын холбооны улсад ч бай, Америкт ч бай, одоо Британид ч бай, Италид ч бай, Францад ч бай энэ бүгд энэ шалгалтууд хийгдэж байгаа. Японд ч бай, Өмнөд солонгост ч бай. Бид бол түрүүн хэлсэн шүү

дээ, бид болбол энэ манай гишүүд өмнөх нь хэллээ, бас бид бол энэ ажлаа болбол их муу байсан учраас түрүүн сая Их Хурлын даргын хэлсэн үг ч байгаа. Хууль хэрэгждэггүй гэдэг ийм яриа чинь одоо 30 жил явлаа шүү дээ. Хууль өөрөө хэрэгжихгүй шүү дээ. Ер нь зүй нь бол хууль хэрэгждэггүй гэдэг яриа ч буруу, хуулийг биелүүлж байх ёстой, хуулийг хэрэгжүүлж байх ёстой байхгүй юу. Түүнээс хууль гэдэг амьгүй юм, өөрөө хэрэгжинэ гэж бол байхгүй. Тэгэхээр энэ хууль хэрэгжиж хуулийн биелэлтийг Монгол Улсын Их Хурлын өмнө Монгол Улсын Ерөнхий сайд хариуцна гээд Үндсэн хуульд биччихсэн байгаа. Хянан шалгах түр хороо гэдэг болбол би олон ашиг тусыг нь хэлэхгүйгээр хэлэхэд энэ бол одоо манай зарим хүн хэлээд байна шүү дээ.

Энэ уг нь бол яг нарийндаа бас парламентын цөөнхөд өгч байгаа боломж. Хамгийн том одоо арга хэрэгсэл. Олонхтойгоо учраа олох, ярилцах, ард түмэнтэйгээ олонх нь ч ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн тодруулж хариулъя. Хууль зүйн байнгын хорооны дарга

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлаас энэ хяналт шалгалтынхаа чиг үүргийг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн долоодугаар зүйл дээр хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцоог дурдсан байгаа. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзэх юм бол төрийн аудитын байгууллага, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл зэрэг шаардлагатай байгууллагуудыг тийм үү, хараат бус одоо хяналт шалгалт явуулах байгууллагад түшиглэж оролцуулж болно оо гээд орчихсон.

Мөн одоо төсвийн хяналт гэж тодорхой төсвийн хяналтын сонсголыг тодорхой, бас бүлгээр орчихсон байж байгаа. Мөн төсвийн хяналтыг хэрхэн яаж тавих вэ гээд. Дөрөвдүгээр бүлэг, хорин нэгдүгээр зүйл дээр, төсвийн хяналтыг тийм үү? Одоо шаардлагатай гэж үзэх юм бол үндсэндээ Монгол Улсын нөгөө хөгжлийн бодлогын бичиг баримтуудад нийцээгүй, төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцээгүй, иймэрхүү төслүүд өргөн барьсан тохиолдол төсвийг одоо буцаах. Урьд нь бол одоо өргөн барьсан төсвийг буцаах зохицуулалт байхгүй байсан бол үүнийг нь өмнө нь урьдчилж хяналт шинжилгээ хийж үзээд тэр дүн шинжилгээ хийж үзээд шаардлага хангаагүй байна аа гээд буцаах хүртэл зохицуулалт энэ хуульд орж ирж байгаа.

Мөн хэрэгжилтийн явцад нь бид нар л ийм явц дунд нь хяналтыг төсвийн хяналтыг хэрэгжүүлэх талаар аудитын байгууллагатай хамтраад, мөн Улсын Их Хурлын Тамгын газартайгаа хамтраад тийм үү, энэ хяналтуудыг хэрхэн яаж зохицуулах вэ гэдэг бас зохицуулалт маш тодорхой орсон байгаа. Хорин дөрөвдүгээр бүлгээр төсвийн хяналт гэсэн бүлэг зүйл байгаа.

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Баагаагийн Баттөмөр.

**Б.Баттөмөр:** Шинэ Үндсэн хуульд Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь түр хороо байгуулах санал гаргавал байгуулж болно оо гэсэн энэ Үндсэн хуулийн заалттай нийцэж байгаа юм аа. Улсын Их Хурал нь хяналт шалгалтын тогтолцоогүй явж ирсэн. Энэ утгаараа бол энэ хууль маш чухал хууль. Гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих үүрэг зайлшгүй байх ийм шаардлага байгаа юм аа.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх Засгийн газрын гаргаж байгаа актууд хуульд нийцэж зүй эсэхэд хяналт тавих тогтолцоо бас хангалтгүй явж ирсэн. Тийм учраас энэ тогтолцоог боловсронгуй болгох, сайжруулах, буруутай хэрэгжүүлэхгүй байхад хариуцлага тооцдог ийм тогтолцоо болбол зайлшгүй ийм чухал шаардлагатай байгаа юм. Тухайлбал өнгөрсөн 30 жилийн хугацаанд гэхэд маш их олон шийдвэр гарсан. Энэ дотор, бас миний мэдэж байгаагаар бол хөгжлийн талаар 500 гаруй бичиг баримт гарсан байдаг. Хамгийн сүүлийн үеийнхээс нь ингээд дурдах юм болбол мянганы хөгжлийн зорилтод тулгуурласан үндэсний хөгжлийн цогц бодлого гэдэг баримт бичиг гарсан. Үүний биелэлтийг бол дүгнээгүй. Ямар биелэлттэй байгаа нь энэ талаар ерөөсөө ямар ч таг чиг. Дараагийнх нь одоо тогтвортой хөгжил 2030 гээд одоо бас зорилт гаргасан. Үүний биелэлт өнөөдөр одоо тэг. Ер нь энэ зорилтыг анхнаасаа боловсруулахдаа бас тодорхой нөхцөл байдалтай уялдуулж хийгээгүй. Өнөөдөр одоо маш муу биелэлттэй явж байгаа.

Хамгийн сүүлд одоо гаргасан энэ Алсын хараа 2050 гээд урьдын баримт бичиг байгаа. Энэ болбол одоо хэрэгжилт үүний талаар бид нар өнөөдөр маш бага ярьж байгаа. Энэ Улсын Их Хурлаас гарч байгаа хөгжлийн баримт бичгүүддээ болбол энэ талаар тусгаж өгөх ёстой. Үүнийг Монгол Улсын хөгжлийн загвар гэж яриад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хөгжлийн загвараа ажил болгох чиглэлд бол өнөөдрийн байдлаар их муу ажиллаж байгаа юм л даа. Ярихгүй байгаад байгаа, ярихгүйгээр юм хийгээд байна уу гэхээр зэрэг хийгээд байгаа юм бас байхгүй байгаа.

Тэгээд шинэ Үндсэн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулаад Ерөнхийлөгч Улсын Их Хурал, Засгийн газрын эрх мэдлийн хуваарилалтыг боловсронгуй болгох шаардлага болбол үүссэн. Энэ шаардлагатай энэ хуулийн төсөл болбол нийцэж байна аа гэж ингэж ойлгож байна. 3 асуулт байна.

Нэгдүгээрт нь, энэ Улсын Их Хурал хяналт шалгалтын бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ энэ хөндлөнгийн шинжээч нар мэргэшсэн зөвлөгч нар төрийн бус байгууллага, олон нийтийг оролцуулах чиглэлээр татаж оролцуулах чиглэлээр юу хийв ээ гэсэн нэг асуулт байна.

Хоёр дахь нь бол Улсын Их Хуралд хяналт шалгалтын тайлагналын системийг яаж бий болгох вэ гэж. Хоёр дахь асуулт нь.

Гурав дахь асуудал болбол хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахдаа тодорхой бүтэц, орон тоо зайлшгүй шаардлагатай. Гэхдээ энэ дээр бол зардал нэмэгдэж гаргахгүй гэсэн ойлголттой байгаа. Энэ зөв үү? Ийм 3 асуултад хариулт авъя аа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн хариулъя.

**Ж.Сүхбаатар:** Тэр юуны хоёр дахь асуудал энэ тэр тайлагнах систем ямар байдлаар бүрдсэн бэ дээр Бямбацогт гишүүн, Мөнхсайхан доктор хоёр болбол энэ хоёр дахь, гурав дахь асуудал дээр хэлчих байх.

Мэргэшсэн байгууллага дээр нь бол иргэний нийгмийн оролцоог яаж хангах вэ гэж. Яг үүнийг төслийг нь долоогийн хоёр, гурав дээр заачихсан байгаа. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцоо болбол мэдээж гол Их Хурлын юмыг бол байнгын, дэд, түр, хянан шалгах гэсэн энэ 4 манай зохион

байгуулалтын хэлбэр бол хэрэгжүүлнэ. Улсын Их Хурал энэ бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзвэл төрийн аудитын байгууллага, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл болон холбогдох бусад хараат бус хянан шалгах чиг үүрэгтэй байгууллагууд дээр түшиглэж явуулна аа. Тэгээд Улсын Их Хуралд эдгээр байгууллагуудын хууль тогтоолд заасан чиг үүргийнх нь хүрээнд Улсын Их Хурлын хяналт, шалгалтад оролцуулахдаа, тухайн байгууллагын хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлж үл болно гэсэн ийм зохицуулалт яваа. Мөн 7.3-т, Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай бол тухайн асуудлаар мэргэшсэн судлаач, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудыг оролцуулна аа гэж байгаа. 7.4-т нь хянан шалгах, бүрэн эрх хэрэгжүүлэхэд Тамгын газар мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ гэж байгаа. Ингээд үзэхээр манай энэ хуулийн хувьд бол би түрүүн урд нь дурдсан Тамгын газрын мэргэжил, арга зүйн удирдлагаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх энэ чиг үүргийг биелүүлэх хүрээнд бол орон тоо, төсвийн хувьд сургалтын хувьд, дэмжлэг туслалцаа авахын хувьд бол шаардлага бол байгаа. Тэгээд төсвийн асуудлын үеэр ч гэсэн бас энэ асуудал яригдсан. Энэ асуудлын талаар болбол Бямбацогт дарга, Их Хурлын дарга, эд нар ч гэсэн бас тодорхой мэдээлэлтэй ийм байгаа. Зүгээр надад бол орон тоо, төсвийн хувьд болбол нэмэгдүүлэх ийм шаардлага байгааг тайлбарлаж хэлсэн. Би үүнийг нь ч бас хүлээж авч байгаа.

Ер нь бол Их Хурал арай өөр түвшинд очъё гэж байгаа шүү дээ. Ер нь болбол. Байж байгаа, одоо энэ явж байгаа байдал, ер нь энэ хууль гарсны дараа болбол Улсын Их Хурал маань стратегийн төлөвлөгөөнийхөө дагуу бол ард түмний төлөөллийн байгууллагынхаа хувьд бол ойрын, ер нь миний ажлын хэсгийн ахлагчийн хувьд төсөөллөөр болбол одоо 2 парламентын дараа болбол Улсын Их Хурал бол олон хууль хэлэлцдэг энэ байдлаасаа татгалзаад байгаа хуулиуд дээрээ одоо яг биелэлтийг нь хянан шалгаад түүн дээрээ дандаа ажиллаж байдаг тэр хууль гол нь биелэгдэхэд л илүү их анхаарал тавьж ажиллах. Бусад улс орнууд чинь нэг хуулийг 1, 2 жил, 3 жил хэлэлцэж байна. Хуулиа өөрчлөхдөө тулахад тулд доод тал нь 10 жилийн дараа өөрчилж байгаа шүү дээ. Тэгээд хууль ойрхон өөрчлөгдөөд байна гэдэг чинь бодлого хурдан тогтворгүй болж өөрчлөгдөөд байна гэсэн үг. Бодлого тогтворгүй, хууль тогтворгүй хоёр чинь нийлээд хөгжлийг алаад байгаа. Тэгэхээр хуулийг тонгочуулдаг болих юм болбол энэ одоо бодлого тогтвортой болно оо гэдэг ийм ёстой логик бол байгаа юм.

Ингээд Бямбацогт дарга, дараа нь Мөнхсайхан багш бас хэлчих бас чухал асуудал. Тайлагнах систем нь яг ямар байдлаар.

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Тэгэхээр сая бас яригдсан л даа. Хууль гэдэг бол бодлого. Хуулийг хэрэгжүүлнэ ээ гэдэг бол бодлогыг хэрэгжүүлнэ ээ гэсэн үг. Тэгэхээр бид хэрэгжиж байгаа хэсэг дээрээ яаж хэмжиж, хяналт тавьж үр дүнг нь тооцдог байх ёстой юм л даа. Тийм үүднээсээ бид нар хяналт шалгалтын тухай хуульд болбол энэ хуулийн мэдээлэл, тайлан илтгэл гэсэн 3 дугаар бүлэг дотроос тавьсан байж байгаа. Мэдээлэл яаж сонсох вэ, тайлан илтгэлийг хэрхэн яаж сонсох вэ, ямар ямар шийдвэр гаргаж болох вэ гээд. Урьд нь бол мэдээлэл тайлан сонсоод өнгөрдөг байсан болбол одоо мэдээлэл тайланг нь сонсоод, хууль, эрх зүйн хувьд ямар бодлогын асуудлууд шийдэх шаардлагатай байна, эндээс ямар нэгэн шийдэл гаргадаг болно. Урьд нь сонсоод л өнгөрдөг байсан бол одоо эндээс

хууль, эрх зүйн хувьд Улсын Их Хурал ийм асуудал дээр анхаарч, хууль, эрх зүйн бодлогоо ингэж өөрчлөх ёстой юм байна. Засгийн газрын хийж хэрэгжүүлж байгаа ажилд ийм алдаа байна, энэ алдааг ингэж засах ёстой юм байна гэдэг ийм шийдэл гаргадаг болох ийм зохицуулалтыг оруулснаараа болбол тайлан нь өөр болсон.

Мөн одоо таны ярьж байгаа Алсын хараа 2050-ийг хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ, энэ олон бодлогуудыг яаж цэгцлэх вэ гэдэг дээр нэгтгэн тайлагнах зарчмыг баримтална аа гэж түрүүн хэлсэн. Дунд хугацаа нь богино хугацаатайгаа, богино хугацаа нь урт хугацаатайгаа, салбарын бодлого нь салбар дундын бодлоготой, салбар дундын бодлого нь үндэсний хэмжээний гэж. Орон нутгийн бодлого нь бүс нутгийн бодлоготой, бүс нутгийн бодлого нь үндэсний хэмжээний бодлоготойгоо. Ийм байдлаар бас уялдуулж ийм байдлаар тайлагнадаг байх юмнуудыг бол бид нар энэ хуулийн хөгжлийн зорилт, хөтөлбөрүүдийн хэрэгжээ явцын болон гүйцэтгэл, тайланг хэрхэн яаж хэлэлцэх вэ? Урт дунд хугацааны, бодлогын баримт бичгүүдээ хэрэгслийн явцын бол гүйцэтгэх тайланг хэрхэн яаж хэлэлцэх вэ гэдэг зохицуулалтуудаар оруулж ирсэн. Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэн тайланг одоо хэлэлцэх гээд. Ийм байдлаар үндсэндээ болбол маш тодорхой болгож өгсөн. Яагаад гэвэл одоо бид өнөөдөр төлөвлөдөг, тайлагнадаг, энэ одоо тогтолцоо энэ соёлд Монгол Улс маань өөрөө, Монгол Улсын төр маань өөрөө бий болгож чадаагүй байна. Тийм учраас энэ соёлыг бий болгох үүднээс энэ одоо хяналт шалгалтын тухай хуульдаа энэ үнэлдэг, дүгнэдэг, хянадаг энэ тогтолцоог бий болгох юмыг нэлээн сайн оруулж өгч байгаа. Энэ Улсын Их Хурлын ч гэсэн сүүлийн 30 жил хийж чадаагүй орхигдуулж ирсэн алдаа.

Улсын Их Хурлын гишүүд, хууль санаачилдаг, ард түмнийг төлөөлдөг энэ хоёр бүрэн эрхээ маш сайн хэрэгжүүлдэг. Ерөөсөө л маш олон хууль санаачлаад л ард түмэнд таалагдах гээд л үзээд байдаг. Ард түмнийг төлөөлж байна гээд тийм үү, төсөвт тойрогтоо мөнгө татах гээд л бөөн юм болдог. Гэсэн мөртөө нөгөө хууль маань амьдрал дээр хэрхэн яаж хэрэгжиж байна гэдгийг хянаж шалгаж, үр дүнг нь тооцож, хуулийнхаа одоо тийм үү, хэрэгжихгүй бол яаж хэрэгждэг болгох вэ, хууль маань буруу гарсан бол яаж засах вэ, хуулийг буруу хэрэгжүүлж байвал Засгийн газар буруу хэрэгжүүлж байвал үүнийг одоо тийм үү, хэрхэн яаж хариуцлага тооцох вэ гэдэг зүйлүүд дээрээсээ анхаарахгүй ирсэн. Үүнийг л одоо 2019 онд хийсэн Үндсэн хуулийн гол өөрчлөлт болбол энэ хяналт шалгалтыг шинэ шатанд гаргах байсан. Энэ хүрээндээ л одоо энэ төлөвлөдөг тайлагнадаг тэр тайланг хэлэлцэх асуудлыг бол маш тодорхой хуульд оруулж өгч байгаа.

**Г.Занданшатар:** Мөнхсайхан доктор 82.

**О.Мөнхсайхан:** Баттөмөр гишүүнд баярлалаа. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хууль батлагдсанаар бол энэ тайлан илтгэл зүгээр нэг сонсдог байдал болбол өөр шатанд гарах олон зохицуулалтууд орж өгсөн байж байгаа. Өмнө нь болбол одоо холбогдох байгууллагуудын тайланг бол хэлэлцээд сонсоод орхидог байсан болбол энэ удаа энэ хууль батлагдсанаар хууль тогтоомжийн биелэлт, түүний үр дүн, асуудал учир шалтгаан, гарц шийдэл нь юу вэ гэдгийг нарийн хэлэлцэх ийм боломжийг олгож байгаа.

Хоёрдугаарт, тайлан мэдээллийг сонсох энэ ажиллагаа бол маш ховор хийгдэж байсан. Жишээлбэл, 2010 оноос хойш үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтийг зөвхөн 1 удаа хэлэлцсэн байдаг. Тэгвэл энэ хууль

батлагдсанаар бол илүү тогтмол хэлэлцэж явдаг болох ийм зохицуулалтууд орсон.

Гуравдугаарт, Монголын хөгжлийн бодлого төлөвлөлтийн 5 суурь баримт бичиг байж байгаа юм. Улсын одоо жилийн хөгжлийн төлөвлөгөө, урт хугацааны төлөвлөгөө гэх мэтчилэн. Тэгэхээр эдгээрийн хэрэгжилтийг болбол явцад нь болон гүйцэтгэлд нь тайлагнах, нийцүүлэх, нэгтгэх, үүнтэй холбоотой тайлан орж ирэхээр болбол Их Хурлын Тамгын газар дээр дүн шинжилгээ хийж, Байнгын хороонд танилцуулдаг тэр дээрээ үндэслээд хэлэлцүүлэг өрнөдөг. Тэр нь өөрөө яагаад хэрэгжиж байгаа юм, хэрэгжихгүй байгаа юм гэдэг шалтгааныг нь бас хэлэлцэх ийм боломж бүрдэнэ ээ гэж харж байгаа.

Хоёрдугаарт, энэ мэргэжлийн байгууллага шинжээчдийг оролцуулах гэж. Тэгээд түрүүн яригдсан хянан шалгах түр хороон дээр бол шинжээчийн мэдүүлэг сонсоно гэж байгаа юм. Тэгээд тэр болбол юу вэ гэхээр тодорхой тэр нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар тухайн хүн болбол мэргэжлийнхээ үүднээс үнэнийг хэлнэ ээ гээд баталгаа гаргаад хэлж байгаа. Хэрвээ худлаа ярих юм бол энэ хуулийн хариуцлага хүлээнэ. Тэгэхээр энэ дээр үндэслээд Их Хурал бол тэр хүний хэлсэн зүйлийг үнэн гэж үзээд шийдвэрээ гаргах ийм боломж бүрдэж байгаа юм.

Хоёрдугаарт, хянан шалгах түр хороон дээр хянан шалгагч гэж тусгайлсан мэргэшсэн хүнийг томилоод мэдээлэл цуглуулах ийм боломжийг болбол процедуртаа нээж өгч байгаа. Дээрээс нь ээ сонсголыг болбол нэлээн нарийсгаж өгч байгаа. Сонсголд бол мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд, судлаачид, хуульчид гэх мэтчилэн хүмүүсийг бол оролцуулах боломж олгосон. Энэ дотроо, жишээлбэл нэр дэвшигчийн сонсголыг болбол нэлээн нарийн процессжуулж өгсөн. Жишээлбэл, Их Хурал дээр танилцуулагддаг, томилогддог, зөвшилцдөг албан тушаалтны санал орж ирэх юм бол танилцуулга материалыг нь Их Хурлын вэб сайт дээр заавал тавина. 14-өөс доошгүй хоногийн дотор иргэдээс асуулт санал авна, тэр нэр дэвшигчтэй холбоотой, мөн энэ хугацаанд бол тэр сонсголд оролцох хүмүүсийг бүртгэнэ. Сонсголд оролцох хүмүүс нь мэргэжлийн хүмүүс нь асуулт санал байх юм бол нэр дэвшигчийн талаар хэлэх энэ баталгааг болбол хуульд тусгаж өгсөн.

Өргөн баригдсан хуулийн төсөлд бол үүнийг бүгдийг нь нэг бүлэг болгоод бичсэн байсан. Гэхдээ ажлын хэсэг дээр яриад хууль дээрээ нарийн зохицуулалтаа хийгээд дагаад Их Хурлын тогтоолоор батлагдах нэр дэвшигчийн сонсголын журам дээр болбол саяын процедурыг хийж өгнө өө гэсэн ийм ойлголцолтойгоор одоо саналын томьёолол явж байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Хаянгаагийн Болорчулуун.

**Х.Болорчулуун:** Баярлалаа. Бид чухал хуулийн талаар бас хэлэлцэж байна аа. Манай Монгол Улс чинь социализмын үед Үндсэн хуулиасаа салбарласан 60, 70-хан хуультай байсан шүү дээ, бүгд мэдэж байгаа. Гэтэл өнөөдөр ардчиллын гэх 30 жилд болбол 700 хууль гарчхаад байна аа. Энэ 700 хуулийн хэрэгжилт үнэхээр хангалтгүй байдаг, үүнийг ард иргэд шүүмжилдэг. Улсын Их Хурлыг одоо шүдгүй арслан мэтээр л бараг шоолдог шүү дээ.

Харин 2019 оны 11 сарын 14-нд батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр болбол бас Улсын Их Хурал тэр Засгийн газрын томилгоонд

оролцохгүй байх, мөн төсөв хөрөнгө оруулалт, Засгийн газраас өргөн барьсан төсөв, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхгүй байх энэ тэр гэж өөрийн эрхээсээ татгалзсан. Гэхдээ Үндсэн хуулийн өөрчлөлт, шинэчлэлтээр болбол хамгийн гол нь Улсын Их Хурал одоо Улсын Их Хурал шиг байх тийм зүйл заалтыг оруулсан явдал болбол энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль л даа. Энэ бол бүх л парламентын засаглалтай оронд байдаг. Бид хууль гаргаад одоо үйлдвэрлээд л орхичихдог биш тэр хуулиа амьдралд хэрэгжүүлэх механизмыг цогцоор нь бий болгох л асуудал. Энэ хууль гарснаар бол бас Улсын Их Хурлын ийм үйл ажиллагаанд ихээхэн өөрчлөлт орно гэж бодож байна.

Надад 2 санал байна.

Нэгд, Улсын Их Хурлаас томилдог, зөвшилцдөг, танилцдаг албан тушаалд нэр дэвшигч бүрээс сонсголыг ямар үе шатаар яаж зохион байгуулах талаар төсөлд нийт 10 хуудас дэлгэрэнгүй зарцуулсан байсан. Гэтэл ажлын хэсэг, Байнгын хорооны саналаар энэхүү зохицуулалтын дийлэнх нь хасахаар санал гаргасан байна. Иймээс нэр дэвшигчийн сонсгол явуулах журмын төслийг шинэчлэн боловсруулж, хоёрдугаар хэлэлцүүлэгт оруулах чиглэлийг ажлын хэсэгтэй Улсын Их Хурлын дарга үүрэг чиглэл болгон өгмөөр байна аа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн 69 дүгээр зүйлд парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байгаа. Гэтэл энэ дагаж гарах Зөрчлийн хуульдаа бол хэрхэн хариуцлага хүлээх, хүлээлгэх тухай тодорхой заагаагүй байна. Өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны сонсголын дэг журам зөрчих, дуудсанаар хүрэлцэн ирэхгүй байх, мэдүүлэг өгөхөөс татгалзах, нотлох баримтыг ирүүлээгүй зэрэг үйлдэлд хариуцлага хүлээлгэхээр тусгасан ч Улсын Их Хурлын Байнгын хороо, дэд хороо, нэгдсэн хуралдааны үед ийм үйлдэл гаргавал хариуцлага хүлээлгэх зохицуулалт төсөлд тусгагдаагүй байна. Ийм учраас үүнийг гүйцээн боловсруулах чиглэлийг Улсын Их Хурлын дарга ажлын хэсэгт өгөх шаардлагатай байна аа гэдгийг хүсэн санал гаргаж байна аа.

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн ажлын хэсэг гүйцээн боловсруулах шаардлагатай гэвэл чиглэл өгөхөд бэлэн байна.

**С.Бямбацогт:** Маш олон хууль баталдаг. Улсын Их Хурал хууль тогтоох дээд байгууллага. Хуулийнхаа хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлдэггүй байсны тод жишээ сая одоо манай аймгийн Ховд аймгийн Мөст сумын тойрог дээр гарсан. Хотонд нь 8 чоно орсон, 8 чоноос буудаад хоёрыг нь алсан. Тэгсэн тэр хүн дээр хэрэг үүсгэсэн, зөрчлийн хэрэг үүсгэсэн. Чи чоно алсан байна. Хонь чинь чононд бариулж байх ёстой байсан байтал чи чоно алсан учраас хууль зөрчсөн байна аа, чамайг одоо шийтгэнэ ээ гэсэн. Яагаад ийм болов гээд судлаад үзсэн чинь 2012 онд Монгол Улсын Их Хурал Амьтны тухай хууль баталсан. Амьтны тухай хуулийн хорин нэгдүгээр заалтад зүйлд нь хориотойгоос, бусад амьтныг ангахдаа, сумын засаг даргаас зөвшөөрөл авна, зохих төлбөр хураамжийг төлнө өө гээд оруулчихсан. Түүнийг нь хэрэгжүүлэх Засгийн газар журам батлахдаа буу эзэмших гэрчилгээтэй, хураамжаа төлсөн дээрээс нь бас юу билээ, зөвшөөрөл авах ёстой. Тэгээд дээрээс нь бас нэг заалт байгаа юм аа, нэг юу тийм хүнд л одоо ан агнах зөвшөөрөл өгнө өө гэхчхэн. Тэгээгүй тохиолдолд Зөрчлийн хуулиар таныг одоо

торгоно, шийтгэнэ шүү гээд ийм хууль баталчихсан. Журам батлаад тэр журмыгаа Зөрчлийн хуульд оруулчихсан. Ингээд ийм байдлаар үндсэндээ бол нөгөө хонь нь бол чононд бариулж байх ёстой. Чоныг болбол зөвшөөрөл авч байж алах ёстой гэдэг хуулийг бид нар баталчихсан. Тэр маань 2012 оноос хойш өдийг болтол хэрэгжээд явж байгаа. Тэр засаг дарга гэрт нь байгаад тэр тусгай зөвшөөрлийг нь өгөөд д төлбөр хураамжаа аваад, буу эзэмших зөвшөөрлөө Улаанбаатар хотын цагдаагийн газарт сургалтад сууж бүртгүүлээд ийм л одоо байдалтай амьдрал дээр бидний баталсан хууль хэрэгжээд байгаа юм аа. Тийм болохоор баталсан хуулийнхаа хэрэгжилтэд нь одоо хяналт шинжилгээ хийдэг, үр дагаврыг нь үнэлдэг, байхгүй болбол энэ асуудал үүсэж байж. Одоо 2012 он хүртэл одоо хэчнээн хүн мэдэхгүйгээсээ болоод хууль зөрчиж, чоно алсныхаа төлөө хэдэн төгрөгөөр торгуулаад ямар шийтгэл авчихсан юм мэдэхгүй. Өнөөдөр ийм хууль байдгийг мэдэхгүй болохоор хүн болгон чоноо алаад тэгээд одоо яагаад явж байгаа юм мэдэхгүй. Ийм л байдалтай байгаад байгаа байхгүй юу. Тийм болохоор бид нар бас энэ хуулийн хэрэгжилтэд үр дагавар, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх асуудлыг бол энэ хяналт шалгалтын хуульд маш том асуудал болгож оруулсан. Жил болгон хийнэ. Жил болгон Улсын Их Хурал юу Засгийн газар хийж тайлангаа яриулж байх ёстой. Үүн дээр нь Улсын Их Хурлын Тамгын газраас үнэлэлт, дүгнэлт өгч Их Хуралд оруулж байх ёстой. Үүнийг жил болгон Их Хурал хэлэлцэж байхаар ингэж оруулж ирж байгаа. Ингэж одоо бас ард иргэдийн амьдралд нийцсэн ийм хуулийг батлах тал дээр Улсын Их Хурал анхаардаг. Баталсан хуулийг бас тийм үү, зөв хэрэгжүүлэх тал дээр Засгийн газар, холбогдох байгууллага нь анхаардаг байхгүй бол бид хэдийгээр одоо зөв бодол санаа хууль баталдаг ч тэр маань амьдралдаа хэрэгжихдээ ингээд нугалаа, завхрал гаргаад эцэстээ ард иргэдийн амьдрал, нийгмийн асуудлыг шийдвэрлэх биш нийгэмд бухимдал төрүүлэх асуудлыг улам хүндрүүлэх ийм л хууль болчихоод байгаа юм.

Тийм болохоор энэ үүднээсээ энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал болбол Засгийн газрын болоод Улсын Их Хурлын бас нэлээн том үүрэг болохоор одоо энэ хяналт шалгалтын тухай хуульд орж байгаа гэдгийг бас хэлье.

Нөгөө асуудлууд дээр Их Хурлын гишүүн, хэн ажлын хэсгийн ахлагч хариулах уу.

**Г.Занданшатар:** Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Болорчулуун гишүүн их чухал санал бас гаргаж байна л даа. Тэгээд бид нар бол ингэж байгаа. Энэ зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдэх юм бол эцсийн хэлэлцүүлэг дээр Зөрчлийн хуульд нэмэлт оруулах төсөл дээр саяын хэлсэн таны санааг бол нэмж оруулж ирэхээр ер нь тооцож байгаа юм. Ер нь эцсийн хэлэлцүүлэг дээр бол дагах хуулийн өөрчлөлтүүд дээр Их Хурлын даргаас чиглэл авахаар бид нар бас тооцож байгаа л даа. Тэгэхээр яг таны хэлдэг үнэн л дээ. Тэр түр хорооны дэгийг зөрчиж байхад чинь ингээд Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэж байгаа юм чинь. Тэгвэл Байнгын хороо чинь бас түр хорооноосоо, одоо дутахгүй илүү эрх мэдэлтэй, яг л адилхан ийм бүтцийн нэгж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бид бас нэг авч үзээд ингээд энэ эцсийн хэлэлцүүлэг дээрээ дэг зөрчил журам, шаардлагатай бол төрийн алба, тогтоолын төслүүд гэдэг юм уу энэ зарчмын зөрүүтэй саналуудаа хурааж дуусангуут нэг багцлаад түүн дээрээ дагах хуулиуд дээрээ нэг ингээд чиглэл аваад ярилцчихъя гэсэн бодолтой байгаа. Тийм учраас Болорчулуун гишүүний хэлж байгаа, одоо санаа оноог бол Занданшатар дарга аа, ерөнхийдөө ажлын хэсэг бол хүлээж авч

байна. Гэхдээ танаас бас тэгээд эцсийн хэлэлцүүлэг дээр дагах хуулиуд дээр оруулж ирэх тэр чиглэл бас авахаар бид нар бол угаас тооцчихсон байж байгаа.

**Г.Занданшатар:** Ойлголоо. Энэ асуудлуудыг гүйцээн боловсруулах эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарах чиглэл өгч байна. Тухайн үед нь бас тодруулж хэлээрэй. Ер нь бол Английн парламентын хуульд бол парламентыг үл хүндэтгэх гэсэн тийм зүйл анги, санкц бий. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй болбол захиргааны хариуцлага хүлээлгэх агуулгатай зохицуулалт байдаг. Парламентад хүндэтгэлгүй хандах гэдэг бол цагт нь ирэхгүй байхаас авхуулаад хоцрох хүртэл, худал мэдүүлэг өгөх, гэрчийн мэдүүлэг худлаа өгөх энэ тэр нөхцөлд гэрчийн мэдүүлэг энэ тэр худлаа өгөх нөхцөлд бол эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Тийм зарим зохицуулалт ч байна. Францын парламентын хууль манайхтай төстэй. Холимог засаглалтай улс гэхэд Францын Үндсэн хуульд шүүхэд үүрэг болгохгүйгээр нотлох баримтыг хүргүүлж болно, мөрдөх байгууллагуудад хүргүүлж болно энэ тэр гээд ийм олон зохицуулалтууд бий л даа, илэрсэн нөхцөлүүдийг. Ер нь бол парламентын засаглалтай сонгодог парламентын засаглалыг төлөвшүүлье гэвэл баталсан хууль тогтоомжийнхоо хэрэгжилтийг яс хянаж шалгадаг энэ тогтолцоо нь бүрдэж бий болж байж л Үндсэн хуулийн хяналт, тэнцэл хангагдана гэж үздэг. Энэ агуулгаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт орсон гэж сая Мөнхсайхан доктор тодорхой тайлбарласан.

Тэгээд энэ агуулгын хүрээнд үзэл баримтлалын хүрээнд гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Энэ хуулийг бол дэмжиж байгаа. Би бас санаачлагчийн нэг нь байгаа юм аа. Тэгээд дэмжиж байгаа 3 шалтгаан дээр 1 асуулт байгаа. Ер нь хууль хоёрдмол утгатай, дутуу дулимаг хууль гарснаараа хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчид төрийн үйлчилгээгээ Үндсэн хуулиар олгогдсон төрийн үйлчилгээгээ авъя аа гэж байгаа иргэдэд хуулийг ашиглаж үгүй гэж хэлж бүр гаршчихсан Монголд бол. Бүр ингээд бүр гаршчихсан. Энэ хууль сөрөг хүчинд хэрэгтэй гэхээсээ илүү эрх баригч нарт хамгийн их хэрэгтэй хууль. Өөрсдийнхөө хорт хавдрыг эрт илрүүлж, дархлаагаа сайжруулах хууль ийм байгаа юм. Тэгээд төр засагт үйлчилгээгээ авах гэж гомдол гаргадаг, иргэд бол үнэхээр хүч нь хүрдэггүй. Энэ гомдоллох эрхийг нь баталгаажуулж байгаа, өөрөөр хэлбэл сонгогчдын эрхийг онцгой хамгаалж байгаа том хууль. Парламент үүнийг 30 жил хэрэгжүүлээгүйгээс болж зүй ёсоороо бидний нэр хүнд унасан байгаа. Үүнийг л хамгаалах гэж байгаа чухал хууль аа.

Тэгээд энэ дээр онцолж хэлэхэд ер нь Улсын Их Хурал болон Их Хурлын гишүүний парламентын гишүүний гуравхан эрх, манайхан эрх гэж орчуулаад байгаа юм, хүч байдаг. Мэдээлэл өгөх, мөрдөн шалгах гэж байгаа шүү дээ. Түүнээс одоо нэг их зайлж зугтаад яах вэ дээ. Хянан хянах гэдэг ийм улбагар сүлбэгэр үг оруулсан явдал бол уг нь буруу л юм байгаа юм. investigating favor гэж нэрлэж байгаа шүү дээ. Бүр хүч. Энэ хүчийг бид өнөөдөр 30 жил ашиглаагүй. Үүнийгээ нэг ашиглах гэж оролдож байгаа хууль.

Гуравт нь, бид хууль баталдаг. Ганцхан тэр 3 дахь ажлаа л хийж байгаа. Эхний хамгийн гол хоёр юмаа хийх гэж оролдож байгаа чухал хууль орж ирж байгаа учраас би дэмжиж байгаа. Тэгээд миний асууж байгаа зүйл бол ер нь энэ нотлох баримт өгөхгүй, худлаа мэдээлсэн тохиолдолд тэр хариуцлагыг нь тооцно

оо гээд заачихсан байна. Яг яаж хариуцлага тооцох вэ гэдэг дээр нэг дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч ээ, ажлын хэсгээс асууж байна.

Хоёрдугаарт, 55.2-т заасан байгаа, тэр худал хэлбэл болон ерөөсөө нотлох баримтаа ирж өгөхгүй байгаа тохиолдолд хариуцлагыг яаж тооцох юм бэ гэдгийг надад дэлгэрүүлж хариулмаар байна. Хоёрдугаарт 55.2-т Шинжээчийг яаж сонгох юм, шинжээчийн өртөг зардал төлбөрийг яг хаанаас яаж гаргах вэ, хуульд заасан гээд л хаячихсан байгаа. Яг аль хуульд яаж заах вэ гэдэг энэ тодорхой зүйл дээр би 2 хариулт авмаар байна.

Эцэст нь энэ хууль онцгой чухал хууль. Бямбацогт, Сүхбаатар гишүүн одоо энэ урдаа барьдаг хуульчид маань энэ дээр ажилласан байна. Яг Германы хууль дээр бол харахад сөрөг хүчин гэхээс илүү бие даагч, яг ард түмний дуу хоолой болоод нөгөө зүгээр жирийн бүтэцтэй намуудыг бодвол асар их хүч гаргаж ирсэн тэр бие даагч нарын байр суурийг энэ дээр нэлээн нөлөөтэй оруулдаг шүү. Дараагийн ажлын хэсгүүд дээр энэ талаар бас санаж байгаа, бодож байгаа, нэмэх ярьж байгаа зүйлүүд байгаа юу? Ингээд энэ хуульгүйгээс болж эцэс төгсгөлгүй парламентын хуулийн хэрэгжилтийг фэйсбүүкээр л дүүрэн ярьдаг улс болж хувирчхаад байгаа шүү дээ. Тэгээд үүнээсээ гарах гарц аа гэж би олж харж байна аа. Ингээд би 2 асуулт, 1 санал юм даа. Түүн дээр тодорхой байр суурийг сонсьё.

**Г.Занданшатар:** Асуултад эхлээд хариулъя. Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Сүүлээс нь эхлээд явчихъя. Ер нь бол яах вэ, бие даагч гэхээс илүүтэй нөгөө цөөнхийн бүлэггүй, цөөнхийн статусын асуудлыг хөндөж байх шиг байна, Ганбаатар гишүүн. Тэгээд яах вэ, ер нь бол энэ манай Монголын парламент ингээд алхам алхмаар урагшилж л байна. Одоо таны, та бол маш оновчтой, бид нарын бас сайхан тодорхойлж хэлж чадахгүй бас сайхан үгийг л хэлж байна л даа. Тэр бол үнэн. Одоо парламент бол дараагийнх нь энэ танин мэдэхүйн нэг эхний шатныхаа хөгжлөөс гараад 21 дүгээр зууныхаа бусад нэг олон улсын парламентын дэг жаяг жишиг, нэр томъёондоо хүртэл шинээр суралцах хэрэгтэй байна шүү дээ. Тэгээд одоо яг хэцүү байгаа учраас шууд тэр мөрдөн шалгахын, жишээлбэл бид нар бас нэг мөрдөн гэдэг үгийг нь аваад зарим тохиолдолд тусгай шалгалт гэж ойлгоё доо гэж ингэж үзэж байгаа юм. Ер нь тэр Бямбацогт гишүүн ч гэсэн тэр хэлж байгаа тэр Үндсэн хууль нь нэг үг байгаа шүү дээ. Улсын Их Хурал онцгой бүрэн эрхтэй байхгүй юу. Энэ онцгой бүрэн эрхээ зарим үед тусгай журмаар хэрэгжүүлдэг л байхгүй юу. Тэгэхээр таны саяын хэлж байгаа энэ асуудал дээр бол ер нь яах вэ, манай энэ хяналт шалгалтын хуулиас гадна Их Хурлын тухай хууль эд нараар бол дараачийн одоо хяналт шалгалтаа хийгээд явсны дээр оролдож байна гэж байна, оролдож байна. Бид. Дараагийн удаа болбол энэ цөөн суудалтай бүлэггүй байгаа тэр намын үйл ажиллагааг ч гэсэн бие даагчийг ч гэсэн ер нь болбол би бол санал нэг байна, зүгээр гишүүний хувьд. Эд нарын статусыг болбол бас бэхжүүлсэн, дэмжсэн байх ёстой. Тэгж байж парламентын дотоод ардчилал, олонх цөөнхийн соёл, цөөнх нь олонхоо хүндэтгэх, олонх нь цөөнхөө бас одоо харж үзэх тэр агуулга руу орно оо гэж бодож байна.

Таны хэлж байгаа тэр түр хорооны гэрч юутай холбоотой асуудал дээр болбол бид нар энд зориуд 69 дүгээр зүйл дээр хариуцлага дээр та бүхэн маань санаачилгатай оруулсан байна. Гэрч хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, мэдүүлэг өгөхгүй татгалзсан бол Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэнэ ээ гээд явж байгаа. Худлаа мэдүүлэг байвал шууд эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээнэ. Түр хорооноос томилсон шинжээч тогтоосон хугацаанд дүгнэлт гаргаж

өгөхгүй хүрэлцэн ирэхээс зайлсхийгээд мэдүүлэг өгөхгүй бол Зөрчлийн хуулиар хариуцлага ноогдуулна. Худлаа дүгнэлт гаргасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Гэрч шинжээч, сонсголд оролцогч ажиглагч, бусад хүн дэг зөрчсөн бол Зөрчлийн хууль гэдэг юм уу, нотлох баримтыг одоо хүндэтгэн үзэх шалтгаанаар ирүүлээгүй, гаргаж өгөөгүй бол Зөрчлийн хуульд гээд ингээд явж байгаа. Ташрамд хэлэхэд ер нь Зөрчлийн хуулиар бид нар бол ингээд тодорхой юмнуудаа ингээд оруулаад батлуулаад явна. Гэхдээ дахиад Хууль зүйн яам, Засгийн газрын зүгээс Зөрчлийн хуулийг багцлаад шинэчилсэн найруулгын төсөл бол бэлдэж байгаа. Олон чиглэлд бол үүнийг анхаарах ийм шаардлага байгаа.

Бид нарын гол түшиглэсэн юм бол ерөөсөө л энэ хуулийн дагуу хариуцлага бол тухай бүрд нь ногдуулахаар үүнийг хууль санаачлагч оруулсан байна лээ. Концепцыг ажлын хэсэг хадгалсан. Тэгээд энэ дээр болбол нэмээд одоо сая чиглэл аваад зарим зүйлүүдийг оруулна аа гэсэн ийм бодолтой байгаа.

Тэр гэрч, шинжээч зардал, төлбөрийн хэмжээ гэдэг болбол ер нь бол зүгээр бусад одоо ажиллагаа дээр хэмжээг бол бас олгодог тийм журмууд байгаа. Зүгээр магадгүй тэр журмуудтай адилтгаад авч үзэж болж байна, эсвэл дахиад холбогдох журмууд бас гарна гэж ойлгож байна. Ер нь бол энэ хянан шалгагчийн ажлын хөлс, мөрдөн шалгалттай холбоотой зардал, нөхөн төлбөр, ажлын хөлсний хэмжээг түр хороо тогтооно гэж байгаа. Түр хорооны энэ одоо гарах зардлууд ер нь улсын төсвөөс санхүүжигдэхээр ингээд заачихсан, энэ байж байгаа. Тэгэхээр одоо цаашдаа бид нар төсөв дээрээ анхаарах ёстой болж байгаа байхгүй юу. Яах вэ, сая төсөв батлагдсан. Бид нар Тамгын газрынхаа хүрээний жаал жуул юмыг бол бага зэрэг ийм тусгасан байгаа. Цаашилбал одоо энэ асуудал дээр улсын төсөв дээр болбол холбогдох юмнууд ажил зүгшрээд ирэхээр энэ зардлуудын асуудлыг нарийвчлах, нэмж тусгах ийм шаардлага болбол зайлшгүй бас гарна л даа. Ер нь бол аливаа юм одоо шинэ зүйлийг хийхэд болбол нэмэлт чиг үүрэгтэй холбоотой нэмэлт зардал, нэмэлт орон тоо гэдэг юм уу, ийм асуудлууд гарна. Ер нь парламентын энэ хяналт шалгалтын асуудал гарснаар бол ер нь Улсын Их Хурал цаашдаа хүний нөөц, төсөв, үйл ажиллагааныхаа зохицуулалтын хувьд бол гүйцэтгэх эрх мэдлээс ер нь хамаарахгүй байх тэр чиглэл рүүгээ явах ёстой. Нэг талдаа эрх мэдэл ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Одоо эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт.

**С.Бямбацогт:** Би тэр хуулийн хэрэгжилттэй холбоотой түрүүн бас нэг тодорхой бас хэлж чадсангүй, одоо хэлчихье гэж бодож байгаа юм аа. 2012 онд Монгол Улсын Их Хурал Амьтны тухай хууль баталсан байгаа юм. Энэ хуульдаа юу гэж заасан гэхэд энэ насанд хүрсэн, буу эзэмших зөвшөөрлөө одоо тийм сургалтад суугаад авсан иргэн зохих төлбөрөө төлөөд, сумын засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж барьж болно гэж заасан байгаа юм. Өөрөөр хэлэх бол хориотойгоос бусад анг бол буутай байх ёстой. Зохих төлбөр төлөх ёстой. Дээрээс нь сумын засаг даргаас нэг удаа эрхийн бичиг зөвшөөрөл авах ёстой. Энэ хуулийг хэрэгжүүлэх журмыг манай Байгаль орчны яам, Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулаад баталсан байх. Ингэхдээ энэ дотор одоо юу гэдэг юм талын саарал чоно гээд талын чоныг болбол бас агнахыг хориглосон. Бусад одоо Алтайд Хангайд байгаа чоно бол малын дайсан учраас хүн болгон л хаа тааралдсан газар ямар ч зөвшөөрөлгүйгээр л хэзээнээс алаад тийм үү, аль болох л цөөлөөсэй гэж бодоод бид нар хүртэл одоо дэмжээд урамшуулаад чоно олсон иргэдийг одоо тийм үү, бензин шатахуунаар, мөнгө төгрөгөөр урамшуулах барих гээд ийм

хөтөлбөр хэрэгжүүлээд ингээд л явж байдаг. Тэгээд нэг талдаа үндсэндээ малын дайсан чоныг бүгдээрээ л алах юм сан. Хядах юм сан, цөөлөх юм сан, малаа өсгөх юм сан гэж. Бүгдээрээ л төрийн бодлого, мал сүрэг төрийн хамгаалалтад байна гээд ийм Үндсэн хуульдаа заалттай. Тэгсэн мөртөө түүнийгээ хэрэгжүүлэх гээд бүгд л үздэг. Гэтэл бидний баталсан хуулийг амьдрал дээр хэрэгжүүлэхдээ ингээд нугалаа гаргаад, тэгээд чоныг бол алахдаа сумын засаг засаг даргаас заавал зөвшөөрөл авна. Нэг удаа. Агнах болгондоо зөвшөөрөл авна, 1 удаагийн зөвшөөрөл. Тэгэхдээ заавал төлбөр төлнө. Тэгэхийн тулд заавал одоо тийм насанд хүрсэн байх ёстой. Буу эзэмших сургалтад суугаад бууны зөвшөөрлийг Улаанбаатар хотод очиж буугаа эзэмших зөвшөөрөл авсан байх ёстой. Буугаа дахиад бүртгүүлсэн байх ёстой. Хэрэв тэгэхгүйгээр чоно алсан байх юм болбол өөрийг чинь чоно алсан, чоныг чинь хурааж авна, дээрээс нь чоно алахдаа хэрэглэсэн машиныг чинь хурааж авна, чоно алахдаа хэрэглэсэн одоо тийм бусад одоо зүйлийг чинь хурааж, буу зэвсгийг чинь хурааж авна. Дээрээс нь торгоно, ийм бодлого. Нэг талдаа бид нар Үндсэн хуулиар мал сүрэг төрийн хамгаалалтад байна. Бүгдээрээ л чоно ална аа гээд үзээд байдаг. Нөгөө талдаа болохоор баталсан хууль маань амьдрал дээр хэрэгжих болохоор чоно алахын тулд төлбөр төлж, чоно төлбөр төлөхгүй, зөвшөөрөлгүй алах юм болбол бүх юмыг чинь хураана шүү, дээрээс нь торгоно шүү гээд нэг хууль хэрэгжүүлдэг. Яг одоо Ховд аймгийн Мөст суманд гарсан болсон явдал энэ. Үүнийг бид нар 2012 онд баталсан хуулийнхаа хэрэгжсэн амьдрал дээр ингээд буруу хэрэгжиж байгаа юм байна гэдгийг 10 жилийн дараа мэдэж байна шүү дээ. 10 жилийн дараа. Энэ чинь л одоо энэ хяналт шалгалтын тухай хууль, хууль тогтоомжийнхоо хэрэгжилтэд үнэлгээ хийгээд үр дагаварт нь үнэлгээ хийдэг асуудал маш ямар чухал байгааг харуулж байгаа. Ийм алдаануудыг засах ёстой. Бид алдаа гаргасан бол Их Хурал өөрөө баталсан хуулийнхаа алдааг доор нь засаж байх ёстой. Хэрвээ бидний баталсан хуулийг хэрэгжүүлэхдээ Засгийн газар, бусад байгууллагууд хэрэгжүүлэхдээ нугалаа гаргасан бол, завхрал гаргасан бол бас засаж байх ёстой. Одоо яг үүгээр үзэх юм бол нугалаа гарчихсан байгаа байхгүй юу. Чоно алах зөвшөөрөл авна, одоо үндсэндээ оготно зурам одоо хулгана алахдаа хүртэл зөвшөөрөл авах ёстой болох гэж байна шүү дээ. Энэ хуулиар болбол. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дагаж гаргасан журмаар болбол. Та хориотойгоос бусад ан хийхдээ ан одоо анд чинь одоо тэр оготно зурам ч, хулгана ч орох байлгүй дээ. Оготно алахдаа хүртэл хулгана алахдаа хүртэл сумынхаа засгаас зөвшөөрөл авч байгаад төлбөр төлж байгаад алддаг л байх ийм журам баталсан амьдрал дээр яваад байгаа байхгүй юу. Ийм л юмнууд чинь ингээд амьдралд, ард түмний дунд одоо үндсэндээ энэ хуулийн хэрэгжилтийн хууль хэрэгжихгүй байна, хууль чинь бас буруу байна. Төрийн бодлого чинь буруу байна гэж биднийг унагааж байгаа юм аа.

Тийм болохоор төр хяналт шалгалтаа сайн тавьдаг, төр хуулиа сайн хэрэгжүүлдэг, хэрэгжүүлэх шат шатанд нь тийм үү, шаарддаг, шахдаг байх ёстой. Энэ үүднээс энэ хуулийн төслийг бас санаачилж боловсруулсан. Үндсэн хуулийн дагуу гэдгийг бас хэлье.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно.

Одоо санал хураалт руу орно. Тэгэхээр санал тус бүр дээр дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг болж болно.

Ингээд 14 цагаас асуулгын хариулт сонсох дэгтэй. Хариулт сонссоны дараа санал хураалтыг үргэлжлүүлж явуулна аа.

Завсарлага болсон тул чуулганы нэгдсэн хуралдааны үдээс өмнөх хуралдааныг завсарлуулж байна.

**Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 43 санал байгаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байгаа.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.2.Улсын Их Хурлын гишүүн өмнө болон одоо хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалын үйл ажиллагаатай холбогдох хяналт шалгалтын ажлын хэсэг, түр хорооны бүрэлдэхүүнд орохгүй.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адьяасүрэн, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, Гочоогийн Ганболд, Мөнхөөгийн Оюунчимэг, Цэндийн Мөнх-Оргил, Бөхчулууны Пүрэвдорж, Жамъянхорлоогийн Сүхбаатар, Нямаагийн Энхболд /Цаашид “Ажлын хэсэг” гэнэ/

Гишүүдээ дууд. Пүрэвдорж гишүүн Ардчилсан намын бүлгийг, Бүлгийн дэд дарга Сүхбаатар Ардын намын бүлгийн гишүүдийг.

Энэ хууль Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу хийгдэж байгаа их чухал хууль. Ер нь хэлэлцүүлгийн үе гүйцээн боловсруулах чиглэл өгөхтэй холбоотой саналууд гарсан учраас санал хураалтын өмнө би бас үүнийг Үндсэн хуулийг эшлээд чиглэлүүдийг хэлж байя. Цаг ашиглаад.

Үндсэн хуульд бол энэ их нарийн асуудал болох юм байна лээ шүү. Өчигдөр Чинбатын Ундрэм гишүүн эртээд Байнгын хорооны хурал дээр архивын хүрээ, сан хөмрөгийн талаар маш чухал асуудал хөндөж ярьсан. Энэ газар усны нэр ус энэ тэр чинь бас их архивын түүхийн баримт энэ тэр чинь өөрөө их нарийн асуудал.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Мөнхбат гишүүн ээ, ажлын хэсгийн дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн ээ. 48-ын 2-ыг дахин боловсруулах, гүйцээн боловсруулах чиглэл өгнө өө. Энэ дээр би нэг холбоотой зүйл хэлэх гээд байгаа юм. Энэ Үндсэн хуульд бол хуулийн биелэлтийг хангах, нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар хяналт шалгалтын түр хороо байгуулж болно гэсэн. Тэгээд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой

асуудлаар гэж байгаа юм. Тэгэхээр энэ ингээд Засгийн газрыг ажил хийлгэхгүй, юм л бол дуудаад түр хороо байгуулаад ийм асуудал болох вий гэсэн ийм болгоомжлол байна. Үүнээс анхаарах хэрэгтэй. Хамгийн гол зорилго нь жишээлбэл, Эрдэнэтийн асуудал шиг тийм нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал гарахад Засгийн газрыг ч гэсэн хувийн хэвшлээ хамгаалах зорилгоор тухайн үед нь Их Хурлын гишүүд энэ асуудлыг хөндөж тавиад, ингэж шийдэж болохгүй юм байна. Их Хурлаар шийдэх ёстой юм байна. Ингээд хяналт шалгалтын түр хороо ажиллах юм бол тэр гарч болзошгүй эрсдэлээс Засгийн газраа ч хамгаалах, хувийн хэвшлийг ч хамгаалах ийм чухал чиглэлтэйгээр энэ хууль батлагдана. Түүнээс биш бүх асуудлаар байж болохгүй. Үүнийг Мөнхбат дарга аа, Байнгын хорооны дарга аа. Анхаарах юм бол ингээд бүх асуудлаар байгуулаад байх юм шиг тэр хязгаарлалтыг эцсийн хэлэлцүүлэг дээр хиймээр юм байна лээ. Хувийн хэвшлийг дуудаад зовоогоод л Засгийн газрын 1 сайдыг 1 тендерээр хэдэн хүн цуглуулаад дуудаад байх юм шиг биш хүний эрхийг зөрчсөн эсвэл нийтийн эрх ашгийг хөндсөн томоохон асуудлаар. Нийтийн эрх ашиг гэдэг чинь олон түмний итгэлийг алдсан асуудлыг хэлж байгаа шүү дээ. Ашиг сонирхлын зөрчлийн хуулиар нийтийн ашиг сонирхлыг хөндсөн гэдэг бол олон түмний итгэлийг алдахад хүргэсэн тийм улс орны эрх ашгийн томоохон асуудлуудаар гэж ойлгож хийхгүй бол тал талдаа буруу ойлголт үүсэхээс хэтрүүлэхгүй, багадуулахгүй байхаас анхаарч эцсийн хэлэлцүүлгээ явуулах шаардлагатай юм байна.

Санал хураалт явуулна. Гишүүдийн нэрийг дуудна аа.

Амгалангийн Адъяасүрэн гишүүн байна. Ширнэнбаньдын Адъяаа гишүүн байна. Норовын Алтанхуяг гишүүн алга байна. Ганибалын Амартүвшин гишүүн алга байна. Чуулганд ирнэ үү. Тлеуханы Аубакир гишүүн байна. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн ажлын хэсгийн гишүүн Баатарбилэг гишүүнийг дуудаарай. Жигжидийн Батжаргал гишүүн байна. Баагаагийн Баттөмөр гишүүн байна. Энхбаярын Батшугар гишүүн байна. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ гишүүн байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн байна. Балжиннямын Баярсайхан гишүүн дуудаарай. Буланы Бейсен гишүүн алга байна. Сая байсан, яасан бэ. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн хэлэлцүүлэгтэй байгаа юм байна. Хэлэлцүүлгээс дуудъя. Сандагийн Бямбацогт гишүүн байна. Дашдондогийн Ганбат гишүүн байна. Хассуурийн Ганхуяг гишүүн дуудъя. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн алга байна. Дуудъя. Бадарчийн Жаргалмаа гишүүн байна. Гомбожавын Занданшатар гишүүн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн байна. Лхагвын Мөнхбаатар гишүүнийг дуудъя. Картаа хийгээд гараад явсан байна. Жамъянгийн Мөнхбат гишүүн байна. Хишгээгийн Нямбаатар гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүнийг дуудъя. Ганбат дарга аа. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Дуудъя. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн байна. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн байна. Шатарбалын Раднаасэд гишүүн алга байна. Говь-Алтай, Ховдын гишүүд гараад явчихсан байна, орж ирээрэй. Цэвэгдоржийн Туваан гишүүн орж ирлээ, байна. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн дуудаарай. Чинбатын Ундрэм гишүүн байна. Тэмүүлэн гишүүн байна. Ням-Осорын Учрал гишүүн, Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн байна. Содномын Чинзориг гишүүн алга байна. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн байна. Нямаагийн Энхболд гишүүн байна.

Санал хураалт явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

Ер нь энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулиас хойш сууна гэдэг бол Улсын Их Хуралд өргөсөн тангаргаасаа хойшоо сууж байгаатай агаар нэг. Ард түмний элч төлөөлөгчийн хувьд нийт ард түмэн, улсын эрх ашгийг дээдлэн гэдэг үг чинь энд хамаарна.

Хуулийн биелэлтийг хангасан, нийтийн эрх ашгийг хангасан тодорхой асуудлаар. Тэгээд бас хязгаартай байхгүй бол хэтрүүлбэл ингээд хэдэн гарын үсэг цуглуулаад бас хүн ажил хийлгэдэггүй байж болохгүй.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.2.Улсын Их Хурлын гишүүн өмнө болон одоо хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалын үйл ажиллагаатай холбогдох хяналт шалгалтын ажлын хэсэг, түр хорооны бүрэлдэхүүнд орохгүй.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адьяасүрэн, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, Гочоогийн Ганболд, Мөнхөөгийн Оюунчимэг, Цэндийн Мөнх-Оргил, Бөхчулууны Пүрэвдорж, Жамъянхорлоогийн Сүхбаатар, Нямаагийн Энхболд /Цаашид “Ажлын хэсэг” гэнэ/

Санал хураалт.

27 гишүүн дэмжиж, 67,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.7.Байнгын хороо хяналт шалгалтын үр дүнд үндэслэн холбогдох санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

27 гишүүн дэмжиж, 67,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсгийг хасч, төслийн дугаар өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Сандагийн Бямбацогт гишүүн горимын санал гаргая. Энэ чинь ямар заалт байгаа билээ.

**С.Бямбацогт:** уучлаарай дарга аа, санал хураалтаас хоцорчихлоо. Кнопондоо хүрч чадалгүй. Дэмжиж байсан. Тийм болохоор энэ санал хураалтыг хүчингүй болгож өгөөч. Горимын санал гаргаж байна.

**Г.Занданшатар:** Бямбацогт гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. 8.8 гэдэг чинь бас. Санал хураалт.

32 гишүүн дэмжиж, 80 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн. Горимын санал дэмжигдсэн учраас 3 дугаар санал хураалтаа дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

29 гишүүн дэмжиж, 72,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4. Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“9 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хэлбэр**

9.1.Улсын Их Хурлын хяналт шалгалт нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэртэй байна.

9.2.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, тайлан, мэдээлэл, илтгэл сонсох, хэлэлцэх, төсвийн хяналт, Байнгын, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу төлөвлөж цаглавар гаргана.

9.3.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, байгууллагын санал, гомдол, мэдээлэл, хяналт шалгалтын дүнг үндэслэн хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан Улсын Их Хурлын гишүүний саналыг харгалзан Байнгын хорооны хяналт шалгалтын цаглаварт тусгаж хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

77,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5. Төслийн 10 дугаар зүйлийн гарчгийг “Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын цаглавар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

33 гишүүн дэмжиж, 82,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6. Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “төлөвлөгөөг” гэснийг “цаглаварыг” гэж, мөн зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийн “цөөнхийн” гэснийг “нам, эвслийн” гэж, мөн зүйлийн 10.2, 10.3 дахь хэсгийн “төлөвлөгөөнд” гэснийг “цаглаварт” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

32 гишүүн дэмжиж, 78 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7. Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлаар” гэснийг “албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

32 гишүүн дэмжиж, 78 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.3 дахь хэсэг нэмэх:

“11.3.Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9. Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “хүлээлгэнэ.” гэснийг “хүлээлгэх үндэслэл болно.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

33 гишүүн дэмжиж, 80,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10. Төслийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг “Асуулга тавьсан гишүүн өөрөө шаардлагатай гэж үзвэл түүний асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

33 гишүүн дэмжиж, 80,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11. Төслийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсгийг “Шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хороо хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний үр дүнг хуралдаанаараа сонсож болно.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12. Төслийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3, 15.5 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.3, 16.4, 16.6, 16.8 дахь хэсгийг тус тус хасах. Тайлбар. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд шилжүүлэн тусгана.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

34 гишүүн дэмжиж, 82,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13. Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтын “хэлэлцүүлэгт бэлтгэх шатны” гэснийг “нэг дэх хэлэлцүүлгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

32 гишүүн дэмжиж, 78 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14. Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.5 дахь хэсэг нэмэх:

“21.5.Энэ хуулийн 23.4-т заасан тооцоог хийхэд шаардагдах Төсвийн тухай хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг тухайн хугацаанд, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн задаргааг зардлын эдийн засгийн ангиллаар, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн задаргааны хамт тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх хугацаанаас өмнөх дараалсан 3 жилийн зэрэгцүүлсэн задаргааны хамт Улсын Их Хуралд ирүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

32 гишүүн дэмжиж, 78 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15. Төслийн 22 дугаар зүйлийн гарчгийг “Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийн үе шатны хяналт” гэж, 22.2 дахь хэсгийн “гаргана.” гэснийг “гарган

Улсын Их Хурлын гишүүдэд тараана.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ.

**Н.Энхболд:** Дэмжиж байгаа. Энэ дээр зүгээр хэлэлцүүлгийн явцад би орхигдсон болов уу гэж бодоод байгаа юм. Энэ нөгөө төсвийн анхны хэлэлцүүлгийг хийх явцад холбогдох хууль тогтоомжид нийцүүгүй бол Засгийн газарт буцаана гэсэн санал байгаа юм. Түүнийг нь хязгаар тавьж өгөхгүй бол эцэс төгсгөлгүй буцаах юм болж магадгүй. Тэгэхээр хугацаатай байдаг юм чинь 1 удаа буцаана гэсэн анхны төслийн хувилбарт явж байсан. Түүнийг нь оруулаад хураачихвал болж байна уу гэж. Эсвэл та эцсийн хэлэлцүүлгээр түүн дээрээ тооцоорой гээд чиглэл өгчихвөл болж байна.

**Г.Занданшатар:** Чиглэл өгөх юм уу, тэгээд. 22.2 шүү дээ, тийм ээ. Зөвлөмж гаргана гэснийг гаргаад гишүүдэд тараана гэж өөрчлөх юм уу.

1 удаа буцаана гэж нэмье гэж үү. 22.4-ийг хэлээд байгаа юм уу.

22.4 дүгээр хэсэгтэй нийцүүлж төсвийн шинжилгээний хяналт шинжилгээтэй хамт энэ буцаах асуудлаа нэг мөр шийдэх чиглэл өгч байна. Гүйцээн боловсруулах. Гүйцээн боловсруулах чиглэл өгсөн учраас санал хураалт явуулахгүй.

16. Төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийг хасч, төслийн дугаар өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

30 гишүүн дэмжиж, 73,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17. Төслийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.2 дахь заалтын “таваас” гэснийг “есөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

32 гишүүн дэмжиж, 78 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18. Төслийн Тавдугаар бүлгийн нэг, хоёрдугаар дэд бүлгийн гарчгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

31 гишүүн дэмжиж, 75,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

19. Төслийн 29 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

29 гишүүн дэмжиж, 70,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

20. Төслийн 30 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“29 дүгээр зүйл.** 30 дугаар зүйлийг 29 дүгээр зүйл гэж нэрлээд доор дурдсанаар өөрчлөн найруулах гэж бичих юм байна шүү. Тэгэхгүй бол 30 гэхээд 29 болчихоод байна.

**29 дүгээр зүйл. Нэр дэвшигчийн сонсгол** 29.1.Эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их

Хурлаас дараах нэр дэвшигчийн сонсгол явуулна:

29.1.1. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Улсын Ерөнхий аудитор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны даргын албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаар томилгооны сонсгол;

29.1.2. хуульд тусгайлан заасан, эсхүл Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол холбогдох Байнгын хороо албан тушаалтныг томилох, зөвшилцөх, танилцах сонсгол.

29.2. Нэр дэвшигчийн сонсгол нь баримт, мэдээлэлд үндэслэсэн, талуудын оролцоог тэнцвэртэй хангасан байх бөгөөд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуульд заасан бусад шаардлага хангасан эсэхийг нээлттэй хэлэлцэж, олон нийт нэр дэвшигчийн талаар мэдэх эрхийг хангахад чиглэнэ.

29.3. Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ явуулна.

29.4. Нэр дэвшигчийн сонсгол явуулахад энэ хууль, Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгох бөгөөд Байнгын хороо сонсголын сэдэв, нэр дэвшигчийн онцлогоос хамааран дэгээ өөрөө тогтоож болно.

29.5. Байнгын хорооны нэр дэвшигчийн сонсгол /цаашид “сонсгол” гэх/ явуулах үйл ажиллагаанд Тамгын газар мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн үг хэлнэ.

**Д.Тогтохсүрэн:** Би өмнө нь ч бас хэлж байсан санал. Байнгын хороон дээр ч хэлж байсан 1 санал байгаа юм аа. 29.1.1 дээр байгаа томилгооны сонсголын албан тушаалтнууд бол дан орон тооны бус хүмүүс байгаа. Орон тооны хүмүүс байгаа юм аа. Орон тооны бус хүмүүсийг нь хасах хэрэгтэй байна аа гэж өмнөх чуулган дээр ч үг хэлсэн, Байнгын хороон дээр ч үг хэлсэн. Тэгээд тэр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл гээд орон тооны бус байгууллагуудыг хассан юм байгаа юм. Энэ дотор энэ Олон нийтийн радио телевизийн үндэсний зөвлөл гээд орон тооны бус 15 гишүүний асуудлыг оруулаад ирсэн байгаа юм аа. Үүнийг хасчихмаар байгаа юм аа. Дараагийн хэлэлцүүлэг дээр. 2 юм байгаа юм.

1 дүгээрт, орон тооны бус хүмүүс. Олон тооны бус хүмүүсийг бид томилгооны сонсгол хийх үү, үгүй юу.

2 дугаарт, энэ Олон нийтийн радио телевизийн хуулиараа маш олон хүн

өрсөлддөг байхгүй юу. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр энэ квотын төлөө 50, 60, 70, 80 хүн өрсөлддөг. Тэгэхээр тэр бүх хүмүүсээ сонсгол хийх болж байгаа юм аа. Их Хурал нэг сонсгол хийсэн л газар бий болчих гээд байгаа юм. Тийм учраас би бол энэ орон тооны бус гэдэг агуулгаар нь Олон нийтийн радио телевизийн зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нарыг энэ заалтаас дараагийн хэлэлцүүлэг дээр хасчихвал яасан юм бэ гэдэг 1 дэх санал.

2 дугаарт нь энэ томилох ч яах вэ ингээд сонсголоо хийчихнэ. Зөвшилцөх болон танилцах сонсголд оруулаад яах юм. Формалны хэлбэр рүү болоод байгаа юм аа. Яагаад вэ гэхээр Их Хурал энэ дээр шийдвэр гаргахгүй. Зөвшилцөх дээр бол гаргана. Танилцах дээр огт гаргахгүй. Сонслоо гэдээ л цохиод л явчихна. Жишээ нь, Дээд шүүхийн шүүгч нар дээр бол. Тийм учраас энэ танилцах сонсгол гэдэг заавал байх хэрэгтэй юм уу үгүй юу гэж би бас боддог юм. Зүгээр нэг хэлбэрийн төдий болчих вий дээ л гэж бодож байгаа юм.

Харин заавал танилцах юу томилгооны сонсголыг зөвхөн Их Хурал гэхгүйгээр тухай нэр дэвшүүлдэг субъект өөр дээрээ сонгон шалгаруулалтын гэдэг юм уу өөр дээрээ томилохын урьдчилсан шатны сонсгол хийдэг тийм хэлбэр рүү байвал яасан юм гэж бодоод байгаа юм. Энэ саналыг хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Түрүүн тэр 25.3 дээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа асуудлаар хяналтын сонсгол явуулахыг хориглоно оо гээд ажлын хэсгээс хассан юм байна лээ. Тэгээд үүнийг бид нар бас нэлээн сайн ярилцах ёстой байх аа. Үүнтэй холбоотой асуудлуудыг хэдийд нь яаж барих бололцоо гарах бол. Энэ бас анхаарах ёстой асуудал байх аа гэж бодож байгаа юм.

2 дугаарт нь сая Тогтохсүрэн дарга бас ярьж байна. Энэ орон тооны бус албан тушаалтнуудыг заавал Их Хурлаар томилгооны сонсгол хийх шаардлага байна уу гэж. Ер нь яах вэ дээ, Их Хурлаар орж ирээд ингээд томилгооны сонсгол болон одоо танилцах сонсгол, зөвшилцөх гээд ер нь Их Хуралд ажлаа тайлагнадаг, мэдээлдэг энэ үед бол бүгдээрээ л аль болох Их Хурлаас орохгүй тойрохыг л боддог л доо. Зугтдаг. Тэр зугтах тусмаа но-той, тийм үү, асуудалтай. Үндэсний олон нийтийн радио телевиз гээд ямар байгууллага билээ. Хуулийг нь бид нар өөрчлөх ёстой. Үнэхээр дампуурчихсан, завхарсан байгууллага шүү дээ. Хуулийг нь өөрчилж байгаад харин тэр томилогдох хүмүүсийг нь бид нар энэ дээр орон тооны бус хүмүүсийг бид нар сонсголоо хийж байгаад томилох ёстой.

Орон тооны бус дахиад Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн байгаа. 9 гишүүнээс 7 нь орон тооны бус. Энэ хүмүүс чинь тэгээд орон тооны бус гээд хасагдах юм уу. Хасагдчих гээд байгаа юм.

Санхүүгийн зохицуулах хорооны бас 7 гишүүний 3 нь орон тооны бус. Ингэх юм бол үндсэндээ энэ хүмүүс ингээд Улсын Их хурлын харьяа байгууллагууд. Улсын Их хуралд жил болгон ажлаа тайлагнаж Улсын Их Хурлаас бодлого чиглэлээ авдаг. Гэсэн мөртөө томилогдож байгаа төрийн албан тушаалтнууд нь бүгдээрээ төрийн өндөр албан тушаалтан гэж явдаг. Тэгсэн мөртөө ингээд сонсголоос зугтаагаад, томилогдохоосоо зугтаагаад байдаг. Тэгээд хэн нэгэн дарга дагаж одоо карманд нь цүнхийг нь барьж явж байгаад сонгогдчих гээд,

томилогдчих гээд нууцаар. Ийм бол байж болохгүй байх аа. Ил тод ярьж байгаад Их Хурал дээр томилдог байх ийм зарчмаар оруулсан юм аа.

Зөвшилцөх сонсголын хувьд бол Улсын Их Хурал дээр бид нар зөвшилцөөд, сонсоод, дэмжихгүй байж болно. Дэмжихгүй бол санал болгосон хүмүүс нь дахиад дараагийн хүнийг нэр дэвших ёстой. Ийм зарчмаар явах юм. Өөрөөр хэлэх юм бол зөвшилцөх нь Улсын ерөнхий прокурор түүний орлогч, Элчин сайд нар, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга Монгол Улсын Ерөнхийлөгч оруулж ирдэг. Оруулж ирсэн хүнээ бид нар зөвшилцөөд энэ хүн чинь болохгүй байна аа. Дэмжих боломжгүй байна гэж үзэх юм бол түүнийг буцаагаад дараагийн хүнийг нь одоо нэр дэвшүүлэх субъект оруулж ирэх ийм зохицуулалтаар орж ирж байгаа.

Танилцах сонсголын тухайд үндсэндээ Улсын Их Хурлын Дээд шүүхийн шүүгч 25 шүүгч байгаа. Танилцлаа. Их Хурал. Үнэхээр олон түмэнд таалагдах нь уу, таалагдахгүй байна уу. Асуудалтай юу, асуудалгүй юу гэдгээ Их Хурал дээр олон нийтийн өмнө ил тод гараад өөрийгөө таниулаад Их Хурал шийдвэр гаргахгүй. Гэхдээ ямар хүнийг томилсон бэ гэдгийг ард түмэн мэдэж аваг. Ийм л зарчмаар шударга бас ил тод явъя гэж байгаа. Ийм агуулгаар энэ томилгооны сонсгол, зөвшилцөх сонсгол, танилцах сонсголыг оруулж ирж байгаа юм аа. Тийм болохоор орон тооны бус тэр төрийн өндөр албан тушаалтнууд. Төрийн өндөр албан тушаалд дуртай. Дарга нар дагаад гүйчихдэг. Их Хурлаар орж ирээд томилгооны сонсгол хийгээд томилогдох гэхээр зугтдаг. Ийм байж таарахгүй ээ. Албан тушаалд дуртай байгаа бол Их Хурлаар шүүлтүүрээр ороод олон нийтэд ил тод бас өөрийгөө үзүүлээд харуулаад гарах нь зөв байх.

**Г.Занданшатар:** Мөнхбат гишүүн.

**Ж.Мөнхбат:** Би яг энэ дээр бол сая бас Бямбацогт гишүүний ярьж байгаатай санал нэг байгаа юм аа. Улсын Их хурал бол төрийн эрх барих дээд байгууллага. Төрийн эрх барих дээд байгууллага дээр орж ирж томилогдож байгаа ямар ч хүн энэ сонсголоор орох хэрэгтэй. Энэ маш том өндөр шалгуур босго тавьж ер нь цаашдаа ажиллах ёстой юм байна лээ. Жишээлбэл, Нийгмийн даатгал ч юм уу Эрүүл мэндийн даатгалынхан эндээс хасагдсан. Гэхдээ энэ чинь нөгөө албан тушаалаараа очиж байгаа юм. Нийгмийн даатгалын гээд тэгэхээр чинь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд байх жишээний ч юм уу. Тийм учраас би одоо үгээ товчилъё. Бямбацогт гишүүний хэлж байгаа байр суурьтай санал нэг байна. Ер нь Улсын Их Хурлаар орж ирж томилогдож байгаа энэ орон тооны ч бай, орон тооны бус ч бай. Төрийн эрх барих дээд байгууллагын босгыг алхаж байгаа хүн бүхэн хэн нь хэн бэ гэдгээ бас Их Хуралд ч ард түмэнд ч тухайн салбартаа ч гэсэн сонсгол хийж өөрийгөө таниулж, ойлгуулж юу хийж байсан, цаашдаа юу хийх юм. Ямар зарчим баримтлах юм, үүнийгээ бас нэг тодорхой болгоод томилогддог байх нь бол зөв гэж бодож байгаа.

**Г.Занданшатар:** Тогтохсүрэн дарга аа. Ерөнхийдөө бас энэ томилгооны сонсгол хийх зарчмууд зөв байх. Гэхдээ түрүүн бас Мөнхсайхан доктор ч Болорчулуун гишүүн ч гэсэн бас үүнийг журмаар зохицуулна. Журмаа эцсийн хэлэлцүүлэгт хамт оруулж ир гэсэн ийм чиглэлүүд өгсөн. Үүнийг бас бусад хууль тогтоомжтой уялдуулж гүйцээн боловсруулах чиглэл өгөх нь зүйтэй байх гэж бодож байна. Тогтохсүрэн гишүүний саналаас гадна байна шүү дээ. Элчин сайд нарын томилгоо гэхэд одоо Нямаагийн Энхболд гишүүн сайн мэднэ, тийм ээ. Томилогдохоос өмнө сонсголоор оруулаад баахан балбаад хаячихдаг. Дараа нь нөгөө айлаасаа agreement хүсээд явуулдаг. Тэгээд улс орны харилцааны

асуудлууд яригдаад явчихдаг. Ийм процедур байна. Тэгээр Элчин сайд нарын томилгоог бас зөвшилцдөг энэ процедурыг эхлээд agreement-аа авчхаад дараа нь Улсын Их хуралтай зөвшилцдөг байх юм уу. Ер нь оруулах хэрэгтэй гэж үзэж байна шүү дээ. Зөвхөн тэгэхдээ түүнийгээ оруулаад тэгээд бусад томилгоо ч гэсэн зөвхөн Их Хурлаас томилогддог оор л хязгаарлагдах биш Тогтохсүрэн гишүүний санаанд байгаа чухал нюанс бол тэр бусад томилгоо ч гэсэн холбогдох газрууд нь хийдэг баймаар байгаа юм. Зөвхөн Их Хурал биш, тийм ээ. Түүнд нь Их Хурал хяналт тавьж оролцдог байж болно. Иймэрхүү байдлаар зохицуулалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Тэгээд журамтайгаа Байнгын хороон дээр Мөнхсайхан доктор бол үүнийг ихэнхийг нь хасчихсан байгаа шүү дээ. Сонсголын юмыг чинь. Ингээд заримыг нь хасаад зарим нь ингээд нэмээд ийм болчих гээд байгаа учраас журамтайгаа хамт оруулж ирээд нэг мөр зохицуулчихъя. Зарим нь журмаар ч зохицуулж болох байх.

Нээлттэй, хаалттай журам энэ тэрийг их тодорхой болгоод журамлачихмаар юм байна лээ. Бараг журмаар зохицуулах нь зөв байж магадгүй. Зарим албан тушаалтныг бас нэмж оруулах шаардлагатай байж болно шүү дээ. Тийм ээ.

21. Төслийн 31, 32 дугаар зүйлийг нэгтгэн, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“30 дугаар зүйл. Сонсгол даргалагч, оролцогч**

30.1. Байнгын хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсгол даргалагчийг сонгох бөгөөд сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална. Сонсгол даргалагч Нийтийн сонсголын тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

30.1.1. сонсголын бэлтгэл хангах;

30.1.2. сонсголыг төвлөсөн цагт эхлүүлж, тогтоосон дэг сахиулах;

30.1.3. сонсголын дэг зөрчигчид хуульд заасан арга хэмжээ авах.

30.2. Сонсголд Нийтийн сонсголын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан оролцогчоос гадна нэр дэвшигч, түүнийг санал болгох эрх бүхий этгээд, эсхүл түүний төлөөлөл оролцоно.

30.3. Эрхэлж байгаа албан тушаалын хувьд сонсголд оролцох үүрэг хүлээсэн төрийн албан хаагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонсголд оролцох, тайлбар өгөхөөс татгалзсан бол Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.17-д заасан нийтийн сонсголыг зохион байгуулах, сонсголд оролцох журам, хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзнэ.

30.4. Байнгын хорооны гишүүн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн<sup>1</sup> 3.1.5-д заасны дагуу нэр дэвшигчтэй хамаарал бүхий этгээд бол энэ тухайгаа сонсгол эхлэхээс өмнө нийтэд мэдэгдэх үүрэгтэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

27 гишүүн дэмжиж, 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22. Төслийн 33, 34, 35, 36, 37, 38, 39 дүгээр зүйлийг нэгтгэн, доор

дурдсанаар өөрчлөн найруулах:

**“31 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсголын үе шат**

31.1.Сонсгол доор дурдсан үе шаттай байна:

- 31.1.1.нэр дэвшигчийг санал болгох;
- 31.1.2.сонсголын тов тогтоох, зарлах;
- 31.1.3.сонсголын бэлтгэл хангах;
- 31.1.4.сонсголыг явуулах;
- 31.1.5.сонсголын тайлан гаргах;
- 31.1.6.сонсголын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулах.

31.2.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу албан тушаалтныг томилох, зөвшилцөх, танилцуулах саналаа Улсын Их Хуралд албан ёсоор ирүүлнэ. Саналд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа талаарх үндэслэл бүхий нэр дэвшигчийн танилцуулга, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, бусад баримт бичиг, мэдээллийг хавсаргана.

31.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын хороо энэ хуулийн 31.2-т заасан саналыг Улсын Их Хурлын чуулганы хугацаанд хүлээн авсан тохиолдолд ажлын 5 өдрийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан тохиолдолд ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор дараах ажиллагаа явуулна:

- 31.3.1.сонсголын тов тогтоож, нийтэд мэдээлэх;
- 31.3.2.энэ хуулийн 31.2-т заасан санал, нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй.

31.4.Хэрэв тухайн Байнгын хороо өөрөө сонгон шалгаруулахаар хуульд заасан бол сонгон шалгаруулалтын дүнг гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор Байнгын хороо энэ хуулийн 31.3-т заасан ажиллагааг хийнэ.

31.5.Байнгын хороо энэ хуулийн 31.3, 31.4-т заасан ажиллагаа явуулснаас хойш 14-өөс доошгүй хоногийн дотор сонсголд оролцогчдыг бүртгэх, нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг бичгээр урьдчилан хүлээн авах бөгөөд шаардлагатай бол тухайн сонсголын дэгийг боловсруулж, батлах зэрэг сонсголын бэлтгэлийг хангана.

31.6.Нэр дэвшигчийг санал болгосноор сонсголын үе шат эхэлнэ. Энэ хуулийн 31.1.4-т заасан сонсгол явуулах хугацаа нь 3 хүртэл хоног үргэлжилж болно.

31.7.Хуульд өөрөөр заагаагүй бол нэр дэвшигчийн сонсголыг нээлттэй явуулна. Хэрэв нэр дэвшигчээс үндэслэл бүхий хүсэлт гаргасныг Байнгын хорооны гишүүдийн олонх дэмжсэн тохиолдолд сонсголыг хаалттай явуулж болно.

31.8.Сонсголын тайланг сонсгол явуулснаас хойш ажлын 5 хоногт гаргах бөгөөд Байнгын хороонд танилцуулж, нэгдсэн хуралдаанд тараана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

28 гишүүн дэмжиж, 68,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23. Төсөлд доор дурдсан агуулгатай 32 дугаар зүйл нэмэх:

**“32 дугаар зүйл.Хяналтын сонсголыг хүчинтэйд тооцох**

32.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын, дэд, түр хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь оролцсоноор тухайн сонсголыг хүчинтэйд тооцно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

27 гишүүн дэмжиж, 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23. Төсөлд доор дурдсан агуулгатай 32 дугаар зүйл нэмэх:

**“32 дугаар зүйл.Хяналтын сонсголыг хүчинтэйд тооцох**

32.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын, дэд, түр хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь оролцсоноор тухайн сонсголыг хүчинтэйд тооцно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

22 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдлээ.

24. Төслийн 40, 41, 42, 43 дугаар зүйлийг хасч, төслийн дугаар өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

29 гишүүн дэмжиж, 70,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25. Төслийн 6 дугаар бүлгийн Нэгдүгээр дэд бүлгийн гарчгаас “/мөрдөн шалгах/” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26. Төслийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “мөрдөн шалгах арга хэрэгслээр” гэснийг “энэ хуулийн 46.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх замаар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

28 гишүүн дэмжиж, 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27. Төслийн 44 дүгээр зүйлийн 44.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“44.9.Хянан шалгах түр хороог зургаан сар хүртэл хугацаагаар байгуулна. Шаардлагатай бол мөн хугацаагаар нэг удаа сунгаж болох бөгөөд хянан шалгах түр хорооны ажиллах хугацаанд тухайн Улсын Их Хурлын бүрэн эрх дуусгавар болсон бол түр хороог татан буугдсанд тооцно. Хянан шалгах түр хороо тайлан, санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулснаар уг хороо татан буугдсанд тооцно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

28 гишүүн дэмжиж, 68,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28. Төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн нэгэн зэрэг хоёроос илүүгүй хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орж

ажиллаж болно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх.

1 чиглэл нэмж өгөх юм байна. 45.1.1 дэх өгүүлбэрийг түр хорооны бүрэлдэхүүний дээд, доод хязгаарыг тогтоох байдлаар өөрчлөн найруулах санал гаргана гэсэн тул нэгдсэн хуралдаан дээр санал хураалгүйгээр гүйцээн боловсруулах чиглэл өгөх юм байна.

Гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

29. Төслийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“45.3.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11.1, 11.2-т заасан олонх, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11.3-т заасан цөөнхийн төлөөлөл энэ хуулийн 45.2-т заасан зарчмын дагуу түр хорооны бүрэлдэхүүнд оруулах гишүүдийн нэрийг өөрөө тогтоож, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ. Байнгын хороо ирүүлсэн нэрийг өөрчлөхгүйгээр хэлэлцэнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн. Санал хураалт.

Байнгын хороо нэрийг өөрчлөхгүйгээр хэлэлцэнэ гэдэг чинь хэлэлцэнэ гэж байна л даа. Шийдвэрлэнэ гэж биш.

28 гишүүн дэмжиж, 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30. Төслийн 46 дугаар зүйлийн 46.1.9 дэх заалтын “газар дээр нь очиж үзэх,” гэсний дараа “нөхцөл байдалтай газар дээр нь танилцах,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

29 гишүүн дэмжиж, 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31. Төслийн 46 дугаар зүйлийн 46.1.12 дахь заалтын “үйлдэл, эс үйлдэхүйн талаарх мэдээлэл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах” гэснийг “үйлдэл, эс үйлдэхүй гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллага, албан тушаалтанд холбогдох баримтыг хүргүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

31 гишүүн дэмжиж, 72,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32. Төслийн 48 дугаар зүйлийн 48.2, 48.3, 48.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.2.Түр хорооны нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах санал гаргасан бол тухайн асуудлаар түр хорооны гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Хэрэв түр хороо уг саналыг дэмжээгүй бол түр хорооны нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах тухай хүсэлтийг Үндсэн хуулийн цэцэд гаргаж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн.

Гүйцээн боловсруулах чиглэл өгье.

Энэ Үндсэн хуулийн цэцийн хэрэг маргаан шийдвэрлэх харьяалалд

одоогийн Үндсэн хуулийн цэцийн хуулиар болохгүй. 1-д.

2-т, үүнийг арай өөр механизмаар түр хорооны шийдвэр цэцийн харьяалалд байхгүй байх. Улсын Их Хурлын шийдвэр гэж байгаа. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

33. Төслийн 55 дугаар зүйлийн 55.3.4 дэх заалтын “газар дээр нь очиж үзэх,” гэснийг “нөхцөл байдалтай газар дээр нь танилцах,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Түрүүн энэ санал хуурчихсан шүү дээ, энэ. Санал хураалт.

Энэ дээр түрүүн хураачихсан даа.

27 гишүүн дэмжиж, 62,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Түрүүн санал хураагдсан. Гэхдээ өөр газар дээр дахин давтагдаж байгаа бол үүнийг нэгтгээд явчхаж байгаарай. Байнгын хороо үүнийг давхардуулж санал хурааж болохгүй.

34.Төслийн 69 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 69.9 дэх хэсэг нэмэх:

“69.9.Холбогдох албан тушаалтан энэ хуульд заасан сонсголд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, эсхүл холбогдох тайлбар, мэдээлэл өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгүүлнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Эрүү, захиргааны хариуцлага хүлээлгэхгүйгээр бол Төрийн албаны хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж уул тэгж байвал зүгээр.

30 гишүүн дэмжиж, 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

30 гишүүн дэмжиж, 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.“төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрийг баримтлах зарчим” гэж Улсын Их Хурал хяналт шалгалтаа хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулиар тогтоосон төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг алдагдуулахгүй байх, хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, тагнуул, прокурор зэрэг байгууллагын хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг болон гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй байхыг;” Санал гаргасан ажлын хэсэг. Цөөнх болсон хэсэг алга байна. Нямаагийн Энхболд гишүүн. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Нийтийн эрх ашгийг хөндсөн асуудал бол хуулиараа олон түмний итгэлийг алахад хүргэсэн асуудлуудыг хэлэх нь дээр.

58,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “гишүүний” гэсний өмнө “энэ хуулийн 13.4-т заасны дагуу гаргасан” гэж, 14 дүгээр зүйлийн 14.8 дахь хэсгийн “цахим санд” гэсний дараа ажлын “10 хоногийн дотор заавал” гэж, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэг дэх хэлэлцүүлгээс” гэж, 46 дугаар зүйлийн 46.1.11 дэх заалтын “тайлан,” гэсний дараа “санал, дүгнэлт,” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.2.1 дэх заалтын “хуульт ёсыг” гэснийг “хуулийг” гэж, мөн зүйлийн 4.1.2, 4.2.2 дахь заалтын “хангах” гэснийг “хамгаалах” гэж, мөн зүйлийн 4.2.4 дэх заалтын “Засгийн газраас” гэснийг “Засгийн газар болон олон улсын байгууллагаас” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “хэтрүүлж” гэснийг “хожимдож” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “тодорхой” гэснийг “хуульд заасан” гэж, мөн хэсгийн “Хурал” гэснийг “Хурлаас” гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “хэлэлцүүлэг эхлэхээс өмнөх” гэснийг “хэлэлцүүлгийн” гэж, 44 дүгээр зүйлийн 44.3, 44.6, 44.7, 44.8, 44.11 дэх хэсэг, 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 50.1, 50.4 дэх хэсэг, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1, 52.5 дахь хэсэг, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.3, 55.6 дахь хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1, 61.2, 61.4 дэх хэсэг, 67 дугаар зүйлийн 67.2, 67.5, 67.6 дахь хэсэг, 68 дугаар зүйлийн 68.1, 68.3 дахь хэсгийн “мөрдөн” гэснийг “тусгай” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтын “/мөрдөн шалгах/” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “зайлшгүй” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.2, 17.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.5, 18.6 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийг 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.4, 20.5, 20.6, 20.7 дахь хэсгийн “дээд” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

72,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдох зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 3 дугаар зүйлийн “18 дугаар зүйлийн 18.5” гэсний дараа “18.7” гэж, мөн зүйлийн “тус тус” гэсний өмнө “18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн “олонх” гэснийг “гуравны нэгээс доошгүй” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

32 гишүүн дэмжиж, 74,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 3 дугаар зүйлийн “гуравны нэгээс” гэснийг “есөөс,” “таваас” гэснийг “есөөс” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

33 гишүүн дэмжиж, 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 4, 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

77,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлээс “14 дүгээр зүйлийн 14.1.13 дахь заалт,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

77,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөлд холбогдох зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбоотойгоор холбогдох хууль тогтоомжийн төсөл шаардлагатай гэж үзвэл боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, мөн нээлттэй сонсголын журмыг дагалдуулж, хэлэлцүүлэхийг чиглэл болгож байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Энэ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна. Энэ хууль бол авлигын индексийг бууруулах, хяналт шалгалт хууль ёсыг дээдлэх зарчмыг хуулиа хэрэгжүүлдэг болохыг, олон хууль батлаад гаргаад байдаг үүнийгээ хэрэгжүүлж чадахгүй байна гэдэг энэ олон шүүмжлэлийг засаж залруулахад чиглэгдсэн томоохон өөрчлөлт болно гэдэгт итгэж байгаа шүү.

Зочдыг танилцуулъя.

Олон Улсын боксын холбооны Ерөнхийлөгч Умар Назарович Кремлев тэргүүтэй төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Ноён Ерөнхийлөгч Умар Назарович Кремлев танд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс, Монгол Улсын Их Хурлын нэрийн өмнөөс таны ажил, айлчлалд өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монголын боксын холбооны Ерөнхийлөгч Хишгээгийн Нямбаатарын урилгаар хүрэлцэн ирсэн. Монголоос боксын олимп, дэлхийн аварга олон төрөх болтугай. Дэмжиж ажиллахыг хүсье.